МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,091,116.. ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.06.27. Даваа. №129 (4499) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



ОНЦЛОХ МЭДЭЭ

ШҮҮХЭД ӨГНӨ, ХУУЛИЙНХАНД ХАНДАНА

V нүүрт

ШУУРХАЙ МЭДЭЭ

"ХЕРО"-ИЙН ЗАХИРАЛ Б.БААТАРЫГ БАРИВЧЛААГҮЙ ГЭВ

VII нүүрт

Дугаарын 60 мөр

## Ялагдлаа хар машинд тохож тэнэгтэх вий

Б.ТОГТОХ

УИХ-ын болон аймаг нийслэлийн сонгууль хоёрхон өдрийн дараа болох нь. Монгол түмэн дөрвөн жилд нэг удаа Үндсэн хуулиар олгогдсон төрийн эрх барих эрхээ эдэлж, үүргээ ч энэ өдөр биелүүлэх учиртай. Ирэх дөрвөн жилд бид хэн байх, хэнээр улс орноо удирдуулах вэ гэдэг түүхэн хариуцлагатай сонголтоо хийх энэ цаг үед элдвийн л хардлага, сэрдлэг гарах бололтой. Өрсөлдөгчдийн нэгнээ түлхэн унагах гэсэн увайгүй үйлдлийг энд бичнэ гэвэл цаг ч бага, цаас ч хүрэхгүй. Өмнөх жилүүдийг бодоход монголчуудын сонголтоо хийх хандлага эрс өөрчлөгдсөн. Мөнгөөр биш толгойгоороо, тархиараа тэд сонголтт хийдэг болсон нь талархууштай. Ардчилсан сонгууль хийх болсон 25 жилийн хугацаанд бид аль нэг намд дийлэнх олонхийг бүрдүүлэх эрхийг өгч үзлээ. Эс бөгөөс эвсэл байгуулах сонголтыг ч өгч байлаа.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ УЛС ТӨР

# "ГУРВАН НАЙЗ" ТҮҮХЭНД ШИНЭ ХУУДАС НЭЭЛЭЭ

Б.ДАВААХҮҮ



Оросын "Renta.ru" сайт Монгол Улсын төрийн тэргүүн Ц.Элбэгдорж, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, БНХАУ-ын дарга Си Зиньпин нарыг "Гурван найз" хэмээн тодорхойлжээ. Бүгд найрамдах Узбекстаны нийслэл Ташкент хотноо болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 16 дугаар хуралдааны хүрээнд өнгөрсөн долоо хоногт мөнхийн хөрш гурван орны төрийн тэргүүнүүд гурав дахь удаагийн дээд төвшний уулзалтаа хийсэн нь тус сайтыг ийн тодорхойлоход хүргэсэн аж. Энэ уулзалтаар "Гурван найз" эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт гарын үсэг зурсан нь түүхэн гэж тодотгохуйц амжилт байсан юм. Энэ асуудал өнгөрсөн хоёр жилийн хугацаанд гурван улсын дунд эрчимтэй яригдаж байсан. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын анхны уулзалтаар гурван тал худалдаа, эдийн засаг, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцож байсан бол 2015 онд төрийн тэргүүн нарын хоёрдахь удаагийн дээд хэмжээний уулзалтаар Монголын "Талын зам" төсөл, БНХАУ-ын "Торгоны замын эдийн засгийн бүс" санаачлага болон ОХУ-ын "Евразийн эдийн засгийн холбоо"-той уялдуулан гурван улсын хооронд "Эдийн засгийн коридор" байгуулахаар тохиролцсоны дагуу хөтөлбөрийн төслийг боловсруулсан байдаг. Төсөлд гурван тал хамтран хэрэгжүүлэх дэд бүтцийн бүтээн байгуулалт буюу авто болон төмөр замын коридорууд, дамжин өнгөрөх тээвэр, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлж, хилийн хянан шалгалтыг хөнгөвчлөх, эрчим хүч, аялал жуулчлал, байгаль орчин, гаалийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, боловсрол, шинжлэх ухаан, техник, хүмүүнлэг, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр 32 төсөл тусгажээ. Тэгвэл энэ удаагийн уулзалтаар талууд гурван баримт бичигт гарын үсэг зурахаар төлөвлөж байсан ч нэг баримт бичгийг ойрын хугацаанд зурахаар хойшлуулсан байна.

Үргэлжлэл нь VI нүүрт

ТЭРСЛҮҮ ҮГ

## МАН-ЫГ СОНГОВОЛ МАНЬ АЖИЛГҮЙ

–Ц.Сандуй: Манай нам ялвал бүгдийг нь солино–

Г.СОРОНЗОН

МАН-ын удирдлагууд төрийн албыг худалдаж, мөнгө босгох төлөвлөгөөгөө ярилцаж байгаа аудио бичлэгийг МАХН-ын Сонгуулийн ерөнхий менежер Э.Эрдэнэжамъян олон нийтэд цацсан билээ. Тэгвэл энэхүү бичлэгтэй холбоотой шуугиан өрнөж буйтай зэрэгцэн, одоогийн төрийн албан хаагчдад зүй ёсны айдас, эргэлзээ төрж эхэллээ. Үнэхээр МАН-ын дарга М.Энхболд, МАН-ын гишүүн А.Ганбаатар, МАН-ын Нийслэлийн намын хорооны дарга Ц.Сандуй нарын ярилцаж буй бичлэг үнэн бол Монголын улс төрийн маш ноцтой баримт юм. Зөвхөн энэхүү бичлэгт дурьдагдсан баримтууд нь авлига, хээл хахууль, албан тушаалын наймаа, эрх мэдлээ урвуулан ашиглах, төрийн албыг худалдах, завших, улс төрийн намын хууль бус санхүүжилт, ашиг сонирхлын зөрчил зэрэг олон гэмт хэргийн жинхэнэ баримт болох учиртай. Тийм ч учраас энэ нь зөвхөн сонгуулийн үеэр анзаараад өнгөрөх баримт биш, араас нь мөшгиж, хариуцлага тооцож, улмаар төрд дахин үзэгдэх нь байтугай үнэртүүлж болохгүй санаархал юм. Ийм санаархал бүхний хоншоорыг тас цохихгүй аваас төрийг мөнгө олох арга хэрэгслээ болгох үзэгдэл тасрахгүй.

### Бичлэг эвлүүлэг гэж үү

"Ичсэн хүн хүн ална" гэж үг бий. МАН-ын зүгээс тус бичлэгийг эвлүүлэг гэсэн тайлбарыг өгсөн. Гэвч сандарсандаа хэд хэдэн баримтын алдаа гаргав. Тодруулбал, энэ бичлэг ямар ч эвлүүлэг биш, бодитой болсон үйл явдал гэдгийг Сандуй дарга нь өөрөө хэлсэн.

Үргэлжлэл нь III нүүрт

ДОТОР НҮҮРТ



ТҮРЭЭСИЙН МӨНГӨНӨӨСӨӨ БАЙРНЫХАА УРЬДЧИЛГААГ ТӨЛӨХ БОЛОМЖТОЙ

7

ҮЗЭЛ БОДОЛ

## Ирц бүрдүүлэх талаар СЕХ юу хийв

Б.ЭРХЭС

Өнөө жил 18 нас хүрч буй дүү маань өчигдөрхөн утас цохив. Тэрбээр, иргэний үүргээ биелүүлж анх удаа сонгууль өгөхийг хүссэн ч хаана ямар байранд очиж өгөх, хэрхэн саналын хуудсаа дугуйлах талаар огтхон ч мэдээлэлгүй учраас мэдээлэл авахаар залгасан нь тэр аж. Мэдээ, мэдээлэлд илүү ойр гэдэг утгаараа энд тэндэхийн сайт ухаж, арайхийн санал авах байр, сонгогчийн санал дугуйлах заавар зэргийг фэйсбүүкээр дүүдээ явуулав. Мэдээж тэр айлд байгаа таван сонгогч яг л адилхан мэдээлэлтэй байгаа нь эндээс ажиглагдаж байлаа. Уг нь сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлснээс хойш Монгол Улсын иргэн нэг бүрт сонгуулиа хэрхэн өгөх тухай мэдээлэл очсон байх учиртай. Гэвч энэ ажлыг хийх учиртай СЕХ маань өнөөдөр юу хийж суунa вэ гэдэгт хариулт эрэхээс өөр аргагүйд хүрч байгаа юм. Миний хувьд гэхэд дөнгөж өчигдөрхөн л санал өгөх заавар гэсэн хоёр хуудас материал гар дээрээ авч байх жишээний.

Үргэлжлэл нь III нүүрт




ДУУЛИАНЫ ЭРГЭН ТОЙРОНД

## ЭВЛҮҮЛЭГ ХҮРТЭЛ ХИЙДЭГ БОЛЖ

С.НЭМЭХ

УИХ болон ИТХ-ын сонгуулийн сурталчилгаа дуусахад хэдхэн өдөр үлдлээ. Энэ хэдхэн өдөрт монголчууд үзээгүйгээ үзэж, сонсоогүйгээ сонсох нь... Бүр намуудын тактик нарийсч бие бие рүүгээ дайрч эхэллээ. Ойрын жишээ гэхэд л Монгол Ардын Намын удирлагуудын дуу хоолойг эвлүүлсэн бичлэг нийгэмд нэлээдгүй тархлаа. Эрх баригчдын амь тавихдаа шидсэн тэсрэх бөмбөг нийгмийг багагүй доргиолоо. Эл үйлдлээс харвал эрх баригчид ялагдах вий гэхээс үхтэлээ айж байгаа юм байна. Учир нь АН энэ удаагийн сонгуульд ялагдвал бүх булхай нь илчлэгдэх учраас тэр шүү дээ. Дөрвөн жил хутгасан холион бантан нь илчлэгдэж, нүүр хийх газаргүй болчих гээд байгаа учраас МАХН-тай хүч хавсран МАН-ыг унагах оролдлого хийж байна... Харамсалтай нь монголын ард түмэн худал, үнэн хоёрыг дэндүү сайн ялгана. Худал хуурмагаар хучигдсан дөрвөн жил ард хоцорч, үнэнд гүйцэгдэхийн даваан дээр эрх баригчид байж болох муу муухай бүхнийг МАН руу чиглүүлж сууна. Өөр олон муу муухай зүйл хийх нь тодорхой. Тэдний гүжир гүтгэлэг ганц нэгээр дуусахгүй. Эрх баригчдын хамгийн сайн хийж чаддаг зүйлүүдийн нэг нь өрсөлдөгчөө хэдэн өнгийн ПИ-АР-аар солонгоруулан будах... Өнөөдөр тэд аудио бичлэг эвлүүлж тарааснаа ард түмний тархийг угаачихлаа гэж эндүүрч яваа. Аягүйдвэл маргааш видео бичлэг эвлүүлчихээд цацаж байж мэдэх л улс. Эрх мэдлийн төлөө улайран зүтгэж байгаа энэ хүмүүс Монгол Улсын төрийг сүүлийн дөрвөн жил ядах юмгүй доройтуулсан шүү дээ. Аргаа барахдаа Н.Батбаяр /Фортуна/ "Өр гэдэг чинь өглөг гэсэн үг. Тийм болохоор өрийг өглөг гэдэг үгээр солих нь зөв" хэмээн дэмийрч байгаад Ч.Хүрэлбаатар гишүүнээс алганы амт амссан. Энэ үйлдэл юу хэлээд байна вэ гэхээр сонгууль дөхсөн учир өөрсдийн балгийг баллуурдах гэсэн л хэрэг. Бүр цаашилбал, Монгол Улсыг дааж давшгүй өрөнд оруулснаа нуух гэсэн үйлдэл. Одоо байтлаа АН-ын дарга нь Монгол Улс өргүй юм шиг, өр байлаа гэхэд МАН тавьчихсан юм шигээр үзэл сурталтаж яваа нь үнэндээ л газар авах шинжгүй байна.

Үргэлжлэл нь IV нүүрт

| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1930.00 | 1945.00 | ФУНТ | 2555.00 | 2787.00 |
| ЕВРО | 2055.00 | 2262.00 | РУБЛЬ | 27.80 | 31.60 |
| ИЕН | 17.89 | 19.83 | ЮАНЬ | 291.00 | 296.00 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1937.00 | 1951.00 | ФУНТ | 2643.00 | 2752.00 |
| ЕВРО | 2122.00 | 2211.00 | РУБЛЬ | 28.00 | 32.60 |
| ИЕН | 18.41 | 19.32 | ЮАНЬ | 293.30 | 297.20 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ХӨНДӨХ СЭДЭВ

# УРАГШГҮЙ ЦАГ ҮЕ РҮҮГЭЭ УХРАХЫН ОРОНД ӨӨДРӨГ ИТГЭЛТЭЙГЭЭР УРАГШИЛЪЯ

Э.ТУУЛ







Нийслэлийн өмнөх удирдлагууд буюу М.Энхболд, Т.Билэгт, Ц.Батбаяр, Г.Мөнхбаяр нар Хотын даргаар ажиллах хугацаандаа 26.9 их наяд төгрөг буюу нийслэлийн 52 жилийн төсөвтэй дүйцэхүйц хэмжээний мөнгийг "салхинд хийсгэж", захирамж нэрээр газар олголт хийсэн болохыг нь Дэлхийн банкны судалгаагаар тогтоосныг уншигч та санаж буй биз. Үүнийг хэн ч эсэргүүцсэнгүй, "би нэг ч газар зараагүй" гээд баттай хэлчих хүн энэ хүмүүсийн дотроос гарч ирсэнгүй. Учир нь нийслэлд алга дарам газар ч үлдээлгүй зарсан хүмүүсийн үнэн дүр төрхийг хэн нэгэн биш, тэд өөрсдөө л илчилсэн байдаг. Газар зарсан гэх энэ баримтыг өөрсдөө хэвлэлээр гаргаж, цагдаад нэгийгээ өгснөөр тодорхой болсон гэнэ билээ. Хотын дарга асан Г.Мөнхбаяр, Т.Билэгт, газрын албаны дарга байсан Ц.Сандуй тэдний гар хөл Э.Ариунгэрэл, Д.Дашцэцэгзэрэг хүмүүсийн 240 удаагийн газрын наймааны хэргийн талаар Сү.Батболдын фракцийнхан цагдаад мэдээлснээр шалгаж эхэлсэн байгаа юм. Тэд сайндаа ч биш өөрийн фракцийн Д.Цогтбаатарыг Барилга, хот байгуулалтын сайдаар томилуулахын тулд өрсөлдөгч фракциас сайдад нэр дэвшсэн Ц.Сандуйгаа унагах гэж үүнийг хийсэн байдаг. Тэдний мэдээллийн дагуу Төрийн данс руу орох ёстой байсан 280 тэрбум төгрөг хаачсаныг тогтоохоор ажиллаж байгаа гэж цагдаагийнхан мэдээлсэн байна билээ. Хэрвээ дээрх газруудыг хууль ёсоор дуудлага худалдаагаар зарсан бол 26.9 их наядаас ч их мөнгө хотын төсөвт орох байв. Дуудлага худалдаа хэзээ ч анхны үнэ дээрээ тогтдоггүйг хүн бүхэн мэднэ. Тэгэхээр бараг нийслэлийн 100 жилийн төсвийг ч тавиад туучихсан ийм л хүмүүс эдүгээ дахин эрх барихын төлөө улайран зүтгэж байна шүү дээ. "Тухайн үед бидэнд ямар ч мөнгө байгаагүй, хэрвээ мөнгө байсан бол өнөөдрийн энэ ажлуудыг хийчих л байсан. Харин эд их мөнгөтэйн дээр косметик мэс засал сайн хийж чадлаа" хэмээн гоншигоноож байсан хүмүүс эдүгээ буруугаа хүлээх нь байтугай бухаж, буруу зөрүү юм ярьж, бүр сүүлдээ нэр хүнд нь шороотой хутгалдаж эхэллээ.

Ерөөсөө улсынхаа нийслэлийн төлөө огт санаа зовдоггүй, энэ мэт газрын наймаачдаас болж, хотын төлөвлөлт эмх замбараагаа алдсан гэхэд хилсдэхгүй. Зай завсаргүй өндөр барилгууд хаягаа дэрлэн сүндэрлэсэн нь бидний нүдэнд илхэн байна. Хүчтэйхэн шиг газар хөдөлбөл нурж унаад, хавь ойроо сүйдэлж мэдэхээр байгаа нь ч үнэн. Эмх цэгцгүй, стандарт зай барьж бариагүй барилга дээрээс элдэв зүйлийн юм унаж, иргэд эрүүл мэнд, амь насаараа хохирох явдал байсхийгээд гардаг байлаа. Энэ бол газраас үүдсэн дайн. Дайн гэж хэлэхэд ч багадахаар хор хохирол учруулсан. Нийслэлийн төв хэсэгт зай завсаргүй газар олгосны хар гайгаар гэр хороолол тэлж, тэр хэмжээгээрээ хөрс, агаарын бохирдол дээд цэгтээ тулсан. Харин энэ муухай нөхцөл байдлыг эдүгээгийн Хотын удирдлагууд засч, залруулж, ажлаа авсныхаа дараа 200 гаруй газрын зөвшөөрлийг хүчингүй болгож, барилга бариагүй, дамлан зарахаар нөөцөлсөн гэх газруудаас дуудлага худалдааны анхны үнийг төлбөрийн хугацаат график гарган нэхэмжилж байгаа аж. 2012-2016 оны хугацаанд нийт 68 тэрбум 493 сая төгрөгийг дуудлага худалдааны анхны үнэ гэж тооцож, төсөвт төвлөрүүлсэн бол 2016-2019 онд 10 тэрбум 506 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцоолсон. Түүнчлэн Дэлхийн банкны гаргасан судлагаанд дурьдагдсан тоо бол дуудлага худалдааны анхны үнээр баримжаалсан тооцоолол юм байна билээ. Хэрвээ дуудлагаар оруулбал газар ямар үнэд хүрдэгийг нийслэлчүүд өнгөрсөн дөрвөн жилд сайн мэдэж авсан. Улаанбаатар хэвлэх үйлдвэрийн газар дуудлагаар ямар үнэд хүрснийг бүгд мэдэж байгаа биз. 3000 орчим ам.метр газар 24 тэрбум төгрөгт хүрч зарагдсан. Тэгвэл дээрх газруудын олголтыг нэгбүрчлэн шалгахад маш их цаг хугацаа, баримт мэдээлэл шаардагдах нь зүйн хэрэг. Түүгээр ч барахгүй "Зүтгэл, сэтгэл, итгэл Эх-орон" төрийн бус байгууллага Чингисийн талбайд "Газраа алдвал бүхнээ алдана" нэртэй үзэсгэлэн зохион байгуулж, хотын үе үеийн дарга нарын хууль бусаар олон нийтийн эрх ашгийг зөрчиж олгосон нийт 67 газрын зураг, гэрчилгээг олсон ч 49-ийг нь нийтэд дэлгэсэн билээ. Уг үзэсгэлэнд дэлгэгдсэн зарим хууль бус материалуудыг иргэд болон аж ахуйн нэгжүүд хамтарч Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүсэлт гаргасны үр дүнд олсон тухайгаа холбогдох эх сурвалж нь мэдэгдсэн юм. Ийм л муу муухай бүхний үүр уурхайг өнөөдөр цэгцлэх гэж үйлээ үзэж байна. Газрын дайныг зогсоож, үнэ цэнэтэй өмчтэй болгох гэж үзэж байна. Сэтгэл байвал ямар ч ажлыг хийж болдгийг бас харууллаа. Өөрсдөө идээд байх бус өмчилж, хувьдаа авч болдгийг бидэнд бас үзүүллээ. Тийм л болохоор урагшгүй цаг үе рүүгээ ухрахын оронд өөдрөг итгэлтэйгээр урагшилъя.

mminfo.mn
Шударга, Шуурхай, Өнгөй мэдээлэл
МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
88873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ӨӨР ӨНЦӨГ

## Монгол Улс АНгалын ирмэг дээр...

С.БУЯН

Монгол Улсыг хүн гэж үзвэл хаашаа ч гарах гарцгүй АНгалын ирмэг дээр зогсож байгаа хүнтэй зүйрлэж болох юм. Өмсөх хувцас, идэх хоолноосоо авахуулаад халаасаа хүртэл эрх баригчдад дээрэмдүүлсэн ард түмэн өөдлөх үү, доошлох уу гэсэн хүндхэн сонголтын өмнө тулж ирээд байна. Сүүлдээ эрх баригч намын дарга нь цэнхэр дэлгэцээр "Монгол Улс өртэй болоогүй. Зүгээр л хуваариар төлөх зээлтэй" гэж ярьж суугаа нь ард түмнийг дэндүү доромжилсон хэрэг болов. "Өр, зээл" гэдэг хоёр үг угтаа ижил юм гэдгийг ард түмэн мэдэхийн дээдээр мэднэ. Чухам яагаад тэнэг хүн хуурч байгаа юм шиг ийм зүйл яриад байгааг ойлгохгүй байна. Өөрсдийн хийсэн балагт үйлийг өөрсдөөсөө холдуулах гэсэн арчаагүй, эцсийн арга нь ч энэ байж мэднэ. "Худал үгийг мянга давтвал үнэн болдог" гэсэн явуургүй зүйрлэлд итгэсэн З.Энхболд онгоц хөлөглөн аймаг аймагт бууж уулзалт хийхдээ өр, зээл гэсэн ижил утгатай үгийг салаа болгон тайлбарлаж байгаа нь Монгол Улсын эмгэнэл. Ямар ч аргаар хамаагүй сонгуульд ялж байвал ард түмний амьдрал, улсын хувь заяа хаашаа шийдэгдэх нь эрх баригчдад огтхон ч хамаагүй. Тэд дөрвөн жил хагартлаа баяжсан. Бүр болохгүй бол гурван үеэрээ идэх хөрөнгөө аваад Америк руу арилж одно. Ийм л бодолтой улс сүүлийн дөрвөн жил Монгол Улсыг жолоочгүй машинтай замчилсан байна. Ингэхдээ тэр жолоочгүй машин нь буруу замаар орж, будаа тээлгээд дууслаа. Энхэл, донхолгүй замаар жолоочтой машинаар замнаж болох байсан ч шавар шалбааг ихтэй замаар жолоочгүй машинтай дөрвөн жил хайр гамгүй давхилаа. Шаварт суусан машинаа гаргаж авах тэнхэлгүй болтлоо сульдсан байна, ард түмэн чинь. Шинэчлэлээс шийдэл рүү гэсэн сайхан уриатай хоёр ч Засгийн газар Монгол Улсыг, ард түмнийг АНгалын ирмэг дээр авчирчихаад "Одоо өөрсдөө учраа олцгоо" гэх гэж байх шиг байна. Хоёр оронтой тооноос нэг рүү гэрлийн хурдаар уруудсан эдийн засаг өнөөдөр дөнгөн данган хоёр хувьд хүрэхтэй үгүйтэй дэнжигнэж байна. Дэнжигнэж байгаа энэ эдийн засгийг хүчтэйхэн үлээхэд хасах руу орно. Ингэснээр З.Энхболд даргын яриад байгаа хуваариар төлөх зээлээ төлж чадахгүйд хүрч дампуурлаа зарлана. Ийм л хүнд нөхцөл байдлыг эрх баригчид сүүлийн дөрвөн жилд ядах юмгүй бүтээчихлээ. Ингэж бүтээснээ гайхамшиг болгон ярих нь бүр их сонирхол татна. Тэд "Монголд хийгдэж байгаагүй бүтээн байгуулалтыг сүүлийн дөрвөн жил бид хийж чадлаа" хэмээн ярих... Нарийндаа Ардын намын үед нэг км-ыг нь 250 сая төгрөгөөр тавьдаг байсан замыг эрх баригчид 1.2 тэрбум төгрөгөөр тавьдаг болсон нь харин бодит үнэн. Өмнө нь 250 сая төгрөгөөр тавьж болоод байсан зам яагаад АН-ынхны үед 1.2 тэрбум төгрөг болоод өсчихөв? Үгүй ядаж 500 сая төгрөг болгон өсгөж болгоогүй юм уу? гэсэн асуултыг ард түмэн эрх баригчдаас асууж байна. Асуултын хариуг хэзээ өгөх вэ эрх баригчдаа. Бүхэл бүтэн 950 сая төгрөгөөр нэмэгдсэн өртгөөр зам барьсан ажлын тайлангаа ард түмэндээ тавьчих. АНгалын ирмэг дээр зогсож байгаа ядарсан ард түмэн чинь маргаашийн хоолоо ч залгуулж чадахгүй болтлоо туйлдсан байна. Сүүлийн дөрвөн жилийн бодит үнэн бол АН-ын таргалсан, ард түмний турсан хоёр л байна даа...

ХЭВЛЭЛИЙН ХУРАЛ

## МАН-ЫН ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ШАЛГУУЛАХААР АН МЭДЭГДЭЛ ГАРГАВ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ЭРХЭС

МАХН-ын дэд дарга Э.Эрдэнэжамъян МАН-ын дарга М.Энхболд болон Нийслэлийн МАН-ын дарга Ц.Сандуй нарын төрийн албыг худалдаж ашиг олох, нийслэлийн агентлаг, хэлтсийн даргын суудлаас гэхэд л 60 тэрбум төгрөгийн ашиг олох тухай ярьж буй бичлэгийг олон нийтэд цацсан нь өнгөрсөн долоо хоногийн гол дуулиан байв. Төрийн албаар наймаалцаж буй эдгээр хүмүүс өдгөө УИХ болон НИТХ-д нэр дэвшиж байгаа бөгөөд МАН-ын зүгээс энэхүү бичлэгийг үгүйсгээгүй нь асуудлыг улам ч ноцтой болгосон юм. Тэгвэл энэ асуудлаар өнгөрөгч бямба гарагт Төрийн ордонд АН-ын дарга З.Энхболд нарын албан тушаалтнууд мэдээлэл хийж, МАН-ын удирдлагуудад хариуцлага тооцуулах тухай мэдэгдэл гаргажээ. Тус мэдэгдэлд "Монгол Ардын намын дарга М.Энхболд, Нийслэлийн Монгол Ардын намын дарга Ц.Сандуй нарын төрийн албыг үнэлэн худалдах санаархал нь Үндсэн хуулийн 46, 19-р зүйл, Эрүүгийн хуулийн 82-р зүйл "Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, хуйвалдаан зохион байгуулах", Төрийн албаны тухай хуулийн 17.1, Сонгуулийн тухай хуулийн 50.1, 70.1.8, Улс төрийн намуудын тухай хуулийн 18.3, Эрүүгийн хуулийн хахууль, албан тушаалын гэмт хэрэгтэй холбогдох олон зүйл анги, заалтуудыг ноцтой зөрчсөн баримт байх тул хууль хяналтын байгууллагад хандан шалгуулахаар шийдвэрлэснээ мэдэгдэж байна. Монголын ард түмний эрх чөлөө, ёс суртахуун, төрийн хууль журмыг дээдлэн сахиж, шударгаар өрсөлдөхийг МАН-аас хатуу шаардаж байна. Эцэст нь МАН-ын удирдлагын дээрх хууль бус, ноцтой үйлдлүүдийг Улсын Ерөнхий Прокурор, Авлигатай тэмцэх газрын удирдлагууд нэн даруй эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхлэхийг шаардаж байна" хэмээжээ.

## МЭДЭГДЭЛ

УИХ-ын ээлжит сонгууль болох хугацаа тулсан энэ өдрүүдэд Төрийн албатай холбогдсон аудио бичлэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тарж, олон нийтийн анхаарлын төвд ороод байна.

Энэхүү мэдээллийг Монгол Улсын төрийн албанд зүтгэж байгаа олон зуун мянган албан хаагчид эмзэглэн хүлээн авч, санаа зовж байгаагаа Төрийн албаны зөвлөлд хандаж илэрхийлэх боллоо.

Төрийн албан тушаалыг мөнгөөр үнэлэх, төрийн албыг улс төржүүлэх, төрийн албан хаагчдыг авлигын сүлжээнд татан оруулах, тэдний ажлын байрны баталгааг алдагдуулах аливаа үзэгдэлтэй тууштай тэмцэж, олон мянган төрийн албан хаагчдынхаа хууль ёсны эрх ашгийг хамгаалж, тэдгээрийг тогтвор суурьшилтай байлгах талаар хатуу байр суурьтай ажиллах болно гэдгээ Төрийн албаны зөвлөл албан ёсоор мэдэгдэж байна.

Олон нийтийн анхаарал татсан энэхүү асуудал нь Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн санаачлан боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг нэн даруй батлан мөрдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг дахин нотлон харуулж байна.

**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**
**2016.06.26**

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

## Ялагдлаа хар машинд тохож тэнэгтэх вий

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Аль алинд нь олонхи өгөхгүй, алаг эрээн парламент бүрдүүлж байсан нь ч саяхан. Эдгээр бүх сонголтыг бид хэн нэг нам, улстөрчийн атгуулсан мөнгө, айл саахалтын дүүгээ дэмжих гэсэн жалга довны явцуу үзлээр хийж байсныг нуугаад яахав. Тэгвэл 2012 оны сонгуулиар Монгол Улс сонгуулийн санал хураалтад шинэчлэл хийж санал тоолох машиныг оруулж ирснээр анх удаагаа иргэдийг санал энд тэнд гээгдэлгүй очих ёстой хүндээ очиж, сонгох ёстой сонголтоо хийж чадсан юм. АН, МАН-ын аль нь ч дийлэнхи олонхийг бүрдүүлээгүй. Гуравдагч хүчний орон зайг бид санал тоолох машины хүчээр бүрдүүлж, хамгийн олон бие даагч сонгогдсон. Өмнө нь гараар санал тоолдог байхад нам эвслүүд иргэдийнхээ саналыг "идэж" орхидог байсан нь худлаа биш. Тиймдээ ч "хар" хэмээн адлуулж буй санал тоолох машин хүн нэг бүрийн саналыг алдахгүй, идэхгүй тоолж чадсан гэдгээрээ яах аргагүй ахиц дэвшил болж чадсан билээ. Гэтэл жил жилийн сонгуулиар яригддаг, хар машинаар санал идэх гэж байна, луйвардах нь гэсэн явуургүй хар пиар өнөө жил дахиад л эрчимжлээ. Иргэд минь хар машинд итгэж л болохгүй шүү гэсэн хачин янзын санал санаачлага ч газар авах шинжтэй. Энэ байдлаараа бол ялагдлаа ч тэд хар машинтай холбож тэнэглэх нь тодорхой байна. Гэвч ардчилсан сонгууль явуулсан 25 жилийн хугацаанд бид үүнээс илүүг олж чадсан бил үү гэж асуумаар байна. Бид хүссэн ч эс хүссэн ч хар машинаар л саналаа тоолохоос өөр аргагүй. Тойргийн штабад ажиллаж буй намын "бууны ноход" саналаа идүүлснээс, санал тоолох машинд уншуулсан нь арай найдвартай гэдгийг 2012 оны сонгууль бидэнд харуулчихсан. Тэгээд ч өнгөрсөн баасан гарагт санамсаргүй аргаар сонгосон зарим нэг тойрогт хяналтын тооллого хийж үзэхэд ямар ч асуудал гараагүй юм билээ. Иргэн та саналын хуудас дугуйлахдаа л алдаа мадаг гаргаж хоёр хүн дугуйлах, эсвэл илүү гаргаж будах зэргээр саналын хуудсаа хүчингүй болгочихгүй л бол санал тоолох машин нэгбүрчлэн тоолж, нэгбүрчлэн санал унших нь тодорхой байгаа юм. Замын дундаас алга болох, эсвэл хакер залуус сууж байгаад нэр дэвшигч Доржид өгсөн таны саналыг нэр дэвшигч Дулмаад болгож өөрчлөх боломж огт байхгүй гэсэн үг. Өмнөх сонгуулийн үеэр энэ мэт хардлага, сэрдлэг гарч байсан учраас улс төрийн намууд өнөө жилийн сонгуулиар 50 хувьд нь хяналтын тооллого хийхээр хуульчилсан. Өөрөөр хэлбэл, хар машины тоолсон нийт саналын 50 хувьд нь хяналтын гар тооллого хийнэ гэсэн үг. Ингэхээр ямар ч маапаан, асуудал үүсэхгүй нь тодорхой. Хар машин болон гар тооллогын дүн эргэлзэхгүйгээр, ямар нэг маргаан үүсгэхгүйгээр таарч байгаа тохиолдолд нэр дэвшсэн горилогчид юу ч яриад нэмэргүй болох билээ. Үүнээс цааш, түүнээс хойш хар машины тухай хардлага байхгүй болж, иргэдийн итгэл ч нэмэгдэх учиртай. Тиймээс иргэдэд дахин хэлэхэд, эхлээд хардаж сэрдэхгүйгээр саналаа өгөөд, дараа нь хяналтын тооллогыг анхааралтай ажиглаарай гэж зөвлөе. Хар машинаас болж ялагдлаа гэсэн хөгийн пиар хийж буй хүмүүст ч итгэх хэрэггүй. Монгол Улс сонгуулийн санал хураалтдаа шинэ жишиг нэвтрүүлснийг дэлхий дахин үнэлчихээд байхад шинэчлэлээс улдан чангааж өмнөх шигээ иргэдийн саналыг нэг биш нэлээд хэдэн зуун мянгаар идэх сонирхолтой хүмүүс л энэ мэт явуургүй пиар хийж, бурууг хар машинаас эрэх нь тодорхой.

## Ирц бүрдүүлэх талаар СЕХ юу хийв

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Гэтэл сонгогчдын сэтгүүл зурагт хуудас өдөр болгон шахуу өрөөнд хөглөрч байна. Манай дүү шиг, надтай адилхан мэдээлэлтэй хүмүүс бишгүй олон бий. Сонгууль хаана ямар байранд очиж өгөхөө мэдэхгүй, анх удаа сонгууль өгч байгаа тохиолдолд саналын хуудсыг яаж дугуйлах талаар тодорхой мэдээлэл аваагүй хүмүүс олон байгаа юм. Нөгөөтэйгүүр, нийгмийн идэвхгүй, санал өгөх ямар ч хүсэлгүй хүмүүс чамгүй олон байдаг нь худлаа биш. Тэр ч утгаараа СЕХ хэвлэл мэдээллээр, сошиалаар, твиттерээр сонгуульдаа хэрхэн оролцох тухай, саналын хуудсаа яаж дугуйлах, хорооны санал авах байр хаана байрлаж буй талаар хамгийн идэвхтэй мэдээлэл түгээж байх учиртай. Хэвлэлийн бүтэн нүүрээр ч хамаагүй хэсгийн хороодын мэдээллийг нийтлээд тараах байх ёстойсон. Харамсалтай нь тэд энэ ажлаа хангалтгүй, бүр чамлахаар хийж байна. Жилээс жилд сонгуулийн ирц, иргэдийн идэвх улам бүр буурч буй. 1992 онд 95.6 хувьтай сонгууль өгч байсан бол энэ ирц жил бүр 10 хувиар буурсаар 2012 онд 65.4 хувьтай байжээ. Өнөө жилийн сонгуулиар ч хэнийг дугуйлахаа мэдэхгүй байна, санал өгчих хүн алга гэсэн бодолтой хүмүүс олон тааралдаж буйг нуугаад яахав. Гудамжинд гараад л захын хүнээс асуухад "манай тойрогт дугуйлчихмаар хүн алга" хэмээн ярьж байгаа. Сошиал медиагаар иргэдийн санал сэтгэгдлийг тандахад ч иймхандлага давамгайлжээ. Олигтойхон идэвхтэй ажилладаг байгууллага бол нэг удаагийн судалгаа хийгээд л хандлагыг өөрчлөх гэж ажиллаж байхсан. Гадны ажиглагчид хүртэл


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

"Өнөө жилийн сонгуулиар ирц хүрэхгүй байх магадлал өндөр байна" хэмээн дүгнэж эхэлжээ. Тухайлбал, Британийн Колумбын их сургуулийн профессор Жулиан Диеркес Монгол Улсын сонгуулийн нөхцөл байдлын талаарх нийтлэлдээ "Ардчилсан нам Засгийн газраас уул уурхайн талаарх баримтлах бодлогод итгэхийг иргэддээ уриалж байхад, МАН эсрэгээрээ Монгол Улсын нийт өрийн тухай ярьж явна. Сүүлийн үед гарсан хамгийн том сурталчилгаа нь Тавантолгойн хувьцааг Засгийн газар эргүүлэн худалдан авах асуудал байв. Энэ бол "Сайн уу сонгогчид оо. Бид танд мөнгө өгье" гэсэн популист үзлийн хамгийн тод жишээ байлаа. Энэ мэт баталгаагүй улс төрийн бодлого сонгогчдод эргэлзээ төрүүлж байна. Мөн ирц бүрдэхгүй байх магадлал өндөр" хэмээн бичжээ. Ер нь ч олон жилийн дундаж, өнгөрсөн хугацаанд болсон нөхөн болон дахин сонгуулийн дүнгээс харахад өнөө жил сонгуулийн ирц 50 хувьдаа хүрэхгүй байх магадлал маш өндөр байгааг нуугаад яахав. Гадны судлаачдаас гадна дотоодын улс төр судлаачид ч үүнийг хэлж байгаа юм. Гэтэл СЕХ өнөөдөр "шүдгүй арслан" гэдэг шиг л үлбэгэр сулбагар ажиллаж байгаад дүгнэлт хийх цаг нэгэнт болж. Энэ байгууллага уг нь иргэдийг мэдээллээр хангахаас гадна, сонгогчдын ирцийг нэмэгдүүлэх талаар ажиллах учиртай. Урамшууллын тогтолцоо бий болгоод ч хамаагүй ирцийг бүрэн хүргэж, үргүй зардал хэмнэх үүрэгтэй байгууллага. Ингэж ажиллах ёстой хэмээн төрөөс ч тодорхой хэмжээний мөнгө өгдөг. Гэтэл сайтууд, өдөр тутмын сонин хэвлэл, зурагт, телевизээс сонгогчдын мэдлэгт зориулсан, сонгуулиа өгөхөд уриалсан тоотой хэдэн материал л олж уншиж байгааг худлаа гэж хэлэхгүй байх. Өдөр тутмын сонин гэдэг бол нийгмийн хамгийн идэвхтэй хэсэг буюу дундаж насныхан уншдаг бүтээгдэхүүн. Өөр, өөрийн гэсэн уншигчтай, нийгмийн хүрээлэлтэй. Цахим орчин бол залуусын "амьдардаг" талбар. Гэтэл фэйсбүүкээр л улс төрийн намууд, нэр дэвшигчид өөрсдөө эвлүүлэг байршуулж, нийгмийн үүргээ ухамсарлахыг уриалахаас биш СЕХ-ны албан ёсны бичлэг, уриалга харагдсангүй. Өдөр тутмын ганц нэг сонинд нэг удаадаа л идэвхтэй оролцохыг уриалсан мэдэгдэл гарснаас биш бусад өдрүүдэд эрээд ч олсонгүй. Цахим сайтын орчинтой бол яриад ч хэрэггүй. Тэр чигээрээ нэр дэвшигчдийн бичлэг, мэдээ байршихаас биш тэгж оролцоорой, ингэж саналаа өгөөрэй гэсэн уриалга, заавар зөвлөгөө, идэвхтэй байхыг уриалсан элдвийн бичлэг алга. Сонгуулиа өгөхийг уриалсан самбар байршуулахыг хуулиар хориогүйгээс хойш рекламын том самбарыг энэ байгууллага жинхэнэ утгаар нь ашиглах ёстой бус уу. Гэтэл тоотой ганц нэгийг л нэрлэхээр байна. Телевизээр ч гэсэн ганц нэгхэн телевизээр бичлэг явж байх аж. СЕХ-ноос бид албан ёсны сайт ажиллуулж байгаа гэх хариулт өгчээ. Тодруулбал, http://songogch.songuuli.gov.mn веб сайт ажиллуулж байгаа бөгөөд тэндээ бүх мэдээллийг байршуулсан гэнэ. Цахим орчинд байнга ажилладаг нийгмийн идэвхтэй хэсэг бол мэдээж ороод харчихна. Гэтэл гэр хороололд амьдардаг, интернет ашиглах боломжгүй, хөдөө суурин газар амьдарч буй иргэдэд энэ мэдээлэл очиж чадах уу. Нэг сайт олонд танигдахын тулд хамгийн багадаа л гурван жилийн нөр их хөдөлмөр зарцуулдаг. Гэтэл хэний ч мэдэхгүй нэг сайт ажиллуулчихлаа гээд сонгогчдыг мэдээллээр бүрэн хангачихлаа гэсэн үг биш. Нөгөө талаар СЕХ-нд шийдвэр гаргах эрх мэдэл тун ч дулимаг байгаа нь илт. Хууль зөрчсөн асуудал болгоныг тэд шийдэхгүй харин цагдаа шийднэ. Цагдаа, шүүхээр асуудал орсны дараа л СЕХ шийдвэр гаргах эрхтэй. Гэтэл эдгээр хэрэг нь цагдаа, шүүхийн шатанд замхрах магадлал маш өндөр. Бүхнийг мөнгөөр шийдэж болдог энэ нийгэмд хүссэн шийдвэрээ мөнгөтэй хүмүүс гаргуулчихдаг. Тиймдээ ч СЕХ-д огтхон ч хамаарахгүйгээр олон ч хэрэг шүүх, цагдаа дээр замхрах магадлал өндөр хэмээн хардахад хүрч байгаа юм. Уг нь шинэ хуулиар бүх л эрх мэдлийг СЕХ-д өгнө хэмээн ярьж байсан ч начир дээрээ нөхцөл байдал өөр байх аж. Шүдгүй арслан архирахаас хэтэрдэггүй шиг л СЕХ-ныхон том нэрнээс цаашгүй л ажиллаж байна даа. Хатуу боловч үнэн байдал ийм л байна. Ирцээ бүрдүүлж чадахгүй дахин хэдэн тэрбумаар "шатаж" байснаас төсөвлөсөн мөнгийг үр ашигтайхан шиг зарцуулж, урамшууллын тогтолцоо хэрэгжүүлээд ч болов улсын мөнгийг хэмнэхсэн, СЕХ-ныхоон.

ТЭРСЛҮҮ ҮГ

## МАН-ЫГ СОНГОВОЛ МАНЬ АЖИЛГҮЙ

–Ц.Сандуй: Манай нам ялвал бүгдийг нь солино–

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

"Манайх дотроосоо бичлэг алдагдсан байна. Хэн алдсаныг олж авна" гэж хэлсэн болохоос "Ийм үйл явдал огт болоогүй, монтаж" гэж огт хэлээгүй. Тэрбээр бичлэг дээр яригдсан албан тушаалын наймаа, төрийн албыг хуйгаар нь үнэлж арилжих тухай өөрийн яриандаа огтхон ч тайлбар хийж чадаагүй юм. Гагцхүү бичлэг яагаад алдчихав гэдгээс өөрийг бодож чадахгүй болтлоо сандарсан байсан хэрэг. Тэгтэл тун удалгүй МАН-ын Нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан мэдээлэл хийхдээ видео мэдээлэл нь бодит байдалд нийцэхгүй, эвлүүлэг гэлээ. Ёстой л хүлээн зөвшөөрч үхсэнээс гүрийсээр байгаад үхсэн нь дээр гэдэг сонголтыг МАН-ынхан ярьж, шийдсэн бололтой. "Живж байгаа хүн сүрэл өвс тааралдсан ч шүүрч авдаг" гэгчийн үлгэрээр энэхүү бичлэг нь эвлүүлэг гэж гүрийхийн тулд хоорондоо огтхон ч авцалдаагүй тайлбаруудыг хийж эхлэв. Ц.Сандуй намын тактик стратегийг ярих үеийн бичлэг байна гэж хүлээн зөвшөөрсөөр байтал ийм яриа огт болоогүй гэж бухав. Тэгснээ "Энэ бичлэг дээрх яриа бол МАН албан тушаал зарах тухайгаа ярьсан яриа биш, харин АН-ынхан ингэж байна гэдгийг ярьсан яриа" гэж хүртэл мангартав. М.Энхболд, Ц.Сандуй, А.Ганбаатар нар тухайн бичлэг дээр "Бид нар, манай нам" гэж байгаад ярьсан нь тодорхой баримтыг ингэж мушгих гэж оролдсон нь ухаангүй явдал байлаа. Энэ талаар МАХН-ын дарга Н.Энхбаяр ч шулуухан үнэнийг хэлсэн юм. Тэр "Би М.Энхболдыг сайн мэднэ. М.Энхболдын дуу, хоолойг нойрон дундаа ч танина. М.Энхболд, Ц.Сандуй нартаа хандаж хэлэхэд, миний дүү нар одоо энэ бичлэгээ өөр намын тухай ярьж байсан зэргээр тайлбарлаж, худлаа ярих гэсний хэрэггүй. Харин эртхэн шиг ёс суртахууныхаа хариуцлагыг хүлээ. Эрүүгийн хариуцлага ч хүлээж магадгүй" гэлээ. Тийм ээ, бичлэг эвлүүлэг биш гэдэг нь хэн бүхэнд илэрхий, тодорхой байсан юм.

### 190 мянган төрийн албан хаагчийн хувь заяагаар тоглох гэж үү

Тэгвэл бичлэг эвлүүлэг биш, үнэн юм бол тэнд дурдагдсан ноцтой баримтуудыг хэрхэх вэ. Энэхүү яриа нь МАН болоод М.Энхболд, Ц.Сандуй нарын талаарх олон яриа таамгийг нэг талаар нотолж буй юм. Тэдэнтэй холбоотой газрын наймаа, албан тушаалын авлигал, хээл хахууль олонтаа яригдаж ирсэн. Саяхан нийслэлийн газрыг энэхүү хоёр эрхмийн үед хэрхэн үнэгүйдүүлэн, хууль бусаар олгосон тухай баримт ч сөхөгдсөн билээ. Төсөвт орж ирэх учиртай байсан асар их мөнгө буюу нийслэлийн 52 жилийн төсөвтэй тэнцэх хэмжээний их хөрөнгийг дээрх бичлэг дээрх шигээ л "Ашиг хийх зорилгоор хувьдаа, намдаа завшчихсан юм биш үү" гэх хардлагыг үндсэндээ баталчихлаа.

Төрийн албан хаагчдын ажлын байрны хувь заяаг ердөө гуравхан хүн нэг өрөөнд сууж уулзаад, шийдэж буй нь үнэхээр аймшиг төрүүлсэн баримт юм. Тодруулбал, МАН ирэх сонгуулиар УИХ болон аймаг, дүүргийн ИТХ дээр олонхи болсон тохиолдолд төрийн албыг бүхэлд нь солих төлөвлөгөөгөө бүр сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө гаргасан нь тодорхой болов. Тэдний гаргасан төлөвлөгөөгөөр бол ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, санхүүгийн эрхтэй дарга, дарга, дэд дарга нарыг мөнгөний албан тушаал болгожээ. Ингэхдээ одоогийн яам, тамгын газар, хэрэг эрхлэх газрууд, орон нутгийн төр захиргааны байгууллагуудыг нэг бүрчлэн хувааж, ахлах албан тушаал бүрийг тухайлан үнэлжээ. Мөнгө өгсөн, эсвэл ирээдүйд мөнгө босгож чадах нэгнийг л эдгээр албан тушаалд томилно гэсэн үг. Хуучин төрийн албан хаагчдыг тэдний золионд гаргана. Үүнийгээ ч Ц.Сандуй бичлэг дээр шууд хэлж байна. "Угаасаа л бүгдийг нь солино шд". Энэ бол маш ноцтой мэдэгдэл. Зөвхөн энэ үгнийхээ төлөө тэр Монголын мянга мянган төрийн албан хаагчдын өмнө хариуцлага хүлээх учиртай.

Төрийн албыг мөнгө гэж хардаг үзэгдлийн тухай хардахдаа хүртэл халгадаг, "Арай ч бас үгүй биз" гэж хайрладаг байсан ард түмнээ МАН-ын дарга нар ийнхүү басамжиллаа. МАН-ынхны боловсруулсан эл схемийн тооцооллоор зөвхөн нийслэлээс 60 тэрбум төвлөрүүлэх тооцоо гарчээ. Ингэхдээ "Бид бүгдийг нь солино" гэсэн үгээр тодотгож буй юм. Ийм байдлаар зөвлөлдөхдөө Монгол Улсын 190 мянга орчим төрийн албан хаагчийн цөм бүтцийг тэр чигээр нь солих асуудалд тэд огтхон ч санаа зовж буй шинж алга. Хамгийн чухал нь намдаа ийм маягаар мөнгө төвлөрүүлэх явдал гэж үзжээ. Мэдээж МАН-ынхны ийм яриаг олон нийт, тэр дундаа төрийн албан хаагчид алга ташаад хүлээн авахгүй. Төрийн албанд тогтвортой ажиллах итгэлгүйгээр, хэзээ ч солигдож халагдаж мэдэх орчин нөхцөлд хүн хэрхэн ажиллах тухай бодох цаг болсон байна. Өнөөдөр төрийн албанд ажиллагсдад тогтвортой ажиллах, хийж буй ажлынхаа эцсийг нь харах, үр дүнг нь үзэх гэсэн ямар ч итгэл найдвар алга. Маргааш хэн нэг нь ирээд халах тушаалыг нь гардуулж, хийсэн ажлынх нь тайланг сөхөж харах ч үгүй хогийн сав руу чулуудах гэж үү.

Итгэл үнэмшилтэй, тогтвор суурьшилтай, авлигад өртөхгүй, албан тушаалаа урвуулан ашиглахгүй, чин зүтгэлтэй, чиглэсэн зорилготой ажиллах бололцоо, хүсэл эрмэлзэлүүнээс улбаалж устаж байна. Төрийн алба ийм барьцгүй, тогтворгүй байхад төрийн залгамж халаа, уламжлал шинэчлэл, төрийн хар хайрцагны бодлого, салбарын тогтвортой хөгжил, хөтөлбөрийн тухай ярих ч утга алга. МАН-ын хэрэв сонгуульд ялалт байгуулбал энэ тухай бүр мартах хэрэгтэй болох нь дээ.

### МАН–ын үнэн нүүр царай

Бичлэг алдагдсанаар үнэндээ МАН-ын үнэн нүүр царайг хуулж, сонгуулийн дараа сандал ширээ тойрсон ямар том өөрчлөлт явагдах нь олон нийтэд тодорхой боллоо. Ажил амьдралаа залгуулж яваа төрийн албан хаагчдын хоолноос нь салгах төлөвлөгөөг ийм тодорхой, ихэд нарийвчилсан схемээр гаргасан нь МАН-ын үнэн дүр төрхийг илчилсэн хэрэг боллоо. Тэд өнгөрсөн олон жилийн төрийн эрх мэдлийг энэ арга, ийм зарчмаараа булингартуулан хиртүүлсэн юм биш байгаа гэх харамсал, халаг эрхгүй төрж байна. Одоо ард түмэн үнэнийг мэдлээ. Албан тушаал худалдах тухай улайрсан төлөвлөгөө зохиогоод сууж байгаа ийм намыг төрийн толгойд гаргахгүй л болов уу. МАН-ын гаргасан энэхүү тогтолцоо яаж ажилладаг болоод ямар хор хохирол дагуулахыг хүн бүхэн мэдэж байгаа нь лавтай. МАН-ын системээр бол бүх хүн мөнгөөр албан тушаалд очно. Мөнгөөр худалдаж авсан албан тушаалаа тэд юуны төлөө ашиглах вэ. Зарцуулсан мөнгөө эргүүлэн олж авах, бүр хэд дахин нугалж олж авахын төлөө л ажиллах нь хэнд ч тодорхой. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, тэд авлига, хээл хахууль авахаас буцахгүй. Албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахаас сийхгүй. Ашиг сонирхлын зөрчилд идэгдэж, ард иргэдийг хохироож, шударга бусыг дэмжинэ гэсэн үг. Ийм л төрийн төлөө МАН болоод түүний дарга нар төлөвлөгөө зохиосон гэсэн үг. МАН-ын хүсч буй ирээдүй, амлаж буй ирээдүй хоёрын хооронд алд дэлмийн зөрүү гарна.

МАН сонгуульд ялсны маргааш юу болох вэ? Тэдний амлаж байгаа шиг гэнэт л сайхан болчих уу. Эсрэгээрээ гэнэт л муу муухай бүхэнтэй Монголын ард түмэн золгох нь эндээс тодорхой байна. Юун түрүүнд, 190 мянган төрийн албан хаагч бүгд халагдаж, гудамжинд гарна. Эдийн засгийн хямралтай, хүндрэлтэй байгаа энэ үед тэдэнд дахин ажил олдохгүй. АН ялагдсанаар Япон руу 100 мянган дадлагажигч ажилтан гаргах ажил ч замхарна. Мөнгөөр албан тушаалд очсон эрхмүүд ард түмэнд хүнд суртал, шударга бус бүхнээр дарамт учруулж, улмаар авлига хээл хахууль дахин цэцэглэнэ. Төрийн албыг зөвхөн мөнгө олох арга хэрэгслээ болгох болно. Татвар, дарамт, хяналт шалгалт, зөвшөөрөл, шат дамжлага тоймоо алдана. Ийм л дүр зураг биднийг хүлээж байна.

# УЛС ТӨР

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

## Н.ЭНХБАЯР: УЛС ТӨРИЙН НАМУУДААС АНХ УДАА МӨРИЙН ХӨТӨЛБӨРӨӨ ЭРДЭМТДИЙНХЭЭ ХЯНАЛТАД ӨГЛӨӨ



С.САРУУЛ

МАХН 2016 оны УИХ-ын сонгуульд дэвшүүлсэн "Хөгжлийн хувьсгал" мөрийн хөтөлбөрөө хөндлөнгөөс хяналт тавих эрдэмтдийн багаар судлуулжээ. Монгол Улс үйлдвэрлэлээ мартсанаас өөрсдийгөө санхүүжүүлэх чадамж огцом буурсан. Харин үйлдвэрлэлийг сэргээснээр хүнд байдлаас гарах бүрэн боломжтой гэж МАХН-ын мөрийн хөтөлбөрийг хөндлөнгөөс хянан шалгах хорооны эрдэмтдийн баг дүгнэж байна. Хөгжлийн хувьсгал мөрийн хөтөлбөрийн явц, хэрэгжилтэд хяналт тавьж хамтран ажиллах салбар бүрийн төлөөллөөс бүрдсэн 25 эрдэмтэнтэй тус намын удирдлага, нэр дэвшигчид гэрээ байгуулсан юм. Талуудыг төлөөлж МАХН-ын дарга, Монгол Улсын гурав дахь Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Мөрийн хөтөлбөрийн хөндлөнгийн хорооны дарга Шинжлэх ухааны доктор, академич, Ардын багш Ч.Авдай нар Санамж бичиг байгууллаа. Энэ үеэр МАХН-ын дэд дарга, сонгуулийн штабын ерөнхий менежер Э.Эрдэнэжамъян "Манай мөрийн хөтөлбөрийн хамгийн гол онцлог бол бид хямралыг давж гарах Хөгжлийн хувьсгал хийх том зорилготой байгаа. Тулгамдаж байгаа асуудлуудыг найман том зорилтын хүрээнд шийдвэрлэнэ. Товч дурьдвал, олон түмний тав тухыг хангасан орчин үеийн шийдэл бүхий жаргалын найман хот барьж Монгол Улс тэгш дүүрэн хөгжинө. Эдгээр хот болон шинээр баригдах үйлдвэр уурхайнуудаа эрчим хүчээр хангах хөгжлийг тэтгэх 3500 мегаватаас доошгүй хүчин чадалтай цахилгаан станц, холыг ойртуулах бараа бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг хямдруулж, үйлчилгээг хурдасгах мянганы төмөр замыг барьж ашиглалтад оруулах зорилго тавьсан. Мөн Жаргалын найман хотод баригдах тэг түрээсийн зарчим буюу зөвхөн ашиглалтын зардлаа төлөх 450 мянган айлыг орон сууцтай болгох, оюутны сургалтын төлбөрийг төрөөс бүрэн хариуцдаг тогтолцоо руу 10 жилийн дотор үе шаттайгаар шилжих, ахмад настан, эх хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, малчдын эрүүл мэндийг төрөөс даах эрүүл мэндийн хамгаалалтын хөтөлбөрийг санал болгож байна. Бүтээн байгуулалтын төслийн үр дүнд сард таван сая төгрөгийн орлоготой чинээлэг дундаж давхаргыг бий болгох, мал эмнэлгийг бүрэн сэргээж хөгжүүлэх санал болгож байна. Энэ хөтөлбөрүүдээ дотор нь илүү нарийвчилж боловсруулсан. МАХН-ын мөрийн хөтөлбөрөө ард түмнийхээ хүсэл санал дээр тулгуурлаж намын дэргэдэх эрдэмтдийн баг боловсруулж Бага чуулганаар батлуулсан. Хөндлөнгийн хяналтын эрдэмтдийн зөвлөл МАХН-ын мөрийн хөтөлбөрийг хэрэгжих боломжтой эсэх, шинжлэх ухааны үндэслэлтэй эсэхийг хянах юм" гэв. Мөн ОМБУДСМЕН буюу МАХН-ын мөрийн хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих эрдэмтдийн багийн зарим гишүүд байр сууриа илэрхийлсэн юм.

### Ч.Авдай: МАХН–ынханд талархаж байна



*/Мөрийн хөтөлбөрийн хөндлөнгийн хорооны дарга Шинжлэх ухааны доктор, академич, Ардын багш/*

-МАХН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зүйлийн хэрэгжилтэд хяналт тавих хяналтын хороог байгууллаа. Өмнө нь намуудын мөрийн хөтөлбөрийг хянадаг хяналтын хороо байсангүй. Олон эрдэмтэд нэгдлээ. Цаашид ч ажилчин, малчдын төлөөлөл оролцоод явах боломжтой. Зорилтдоо ямар замаар хүрэх вэ гэдэгт хяналтын хорооны гишүүд мөн туслах ёстой. Аль ч намын мөрийн хөтөлбөрт хяналт тавих бололцоотой. Харин биднийг урьж улс орныхоо хөгжлийг хөтлөх мөрийн хөтөлбөртөө дүн шинжилгээ хийлгэж, хяналт тавиулсан МАХН-ынханд талархаж байна.

### С.Шагдаржав: МАХН–ын мөрийн хөтөлбөрт авууштай зүйл олон бий



*/Монгол Улсын шилдэг зохион бүтээгч, МЗБНХ-ны тэргүүн/*

-МАХН-ын мөрийн хөтөлбөрт авууштай зүйл олон бий. Төвлөрлийг сааруулах үйлдвэржилтийг хөгжүүлэх хотуудыг байгуулах дээрээс нь мянганы төмөр зам барих гээд хэрэгжих боломжтой санаанууд байна. Бас нэг анхаарал татаж байгаа зүйл бол аливаа улс орон оюуны өмчөө эргэлтэд оруулж байж хөгждөг жамтай. Энэ хөтөлбөрт шинжлэх ухаан, боловсролын салбараа нэлээд дэмжсэн бодлого их бий. Түүнд талархаж байна. Гэтэл өнгөрсөн жилүүдэд шинжлэх ухааны салбараа цомхотгож унтраасан шийдвэрүүд их гарлаа. Эцсийн эцэст Монгол Улсыг хөгжүүлж чадах тэр хүчийг дэмжье гэж бодож байна.

### Х.Цэрэндаш: Манай улс эрдэмтдийн хүч оюуныг ашиглах ёстой



*/Техникийн ухааны доктор/*

-Эрдэмтдийн санаа бодлыг уралдуулж байгаа учраас мөрийн хөтөлбөр улам сайжраад явах юм байна. Манай улс эрдэмтдийн хүч оюуныг ашиглах ёстой. Үйлдвэржих асуудал чухал. Техник технологийг үйлдвэртээ нэвтрүүлснээр Монгол Улсын хөгжлийн суурь тавигдах ёстой. Бүсчилсэн найман хотод үйлдвэржилтээ хөгжүүлээд, тэднийгээ мянганы төмөр замаар холбоно гэж байгаа. Дээр нь эрдэмтдийн хяналтын хороо байгуулж байгаа нь шинэлэг зүйл.

### И.Эрдэнэбаатар: Мөрийн хөтөлбөр хэрэгжих бүрэн боломжтой



*/Техникийн ухааны доктор, Монгол Улсын шилдэг зохион бүтээгч/*

-Би энд зөвхөн нэг чиглэлийг нь ярья. Бид хөдөө аж ахуйн болон газар тариалангийн бүтээгдэхүүнээ дотооддоо боловсруулахад хэрэгцээтэй тоног төхөөрөмж үйлдвэрлэлийн чиглэлийн зүйлийг маш хурдан хөл дээр нь босгох хэрэгтэй. Ийм бололцоо бий. Дараагийн машин, техникийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бааз суурь нь болж өгнө. Гадаад руу урсч байгаа тэр их мөнгийг эх орондоо шингээнэ гэдэг зөв санаа. Мөрийн хөтөлбөрийг тал талаас нь шүүн тунгаагаад зөв дараалаар явах юм бол хэрэгжих бүрэн боломжтой.

### Г.Дорлиг: Мөрийн хөтөлбөртөө хөндлөнгийн хяналт тавиулах зоригтой байна гэдэг маш чухал



*/УАУ-ийн удирдах зөвлөлийн гишүүн, Монгол Улсын шилдэг зохион бүтээгч/*

-Мөрийн хөтөлбөртөө хөндлөнгийн хяналт тавиулах зоригтой байна гэдэг маш чухал. Мянганы төмөр зам Монгол Улсын хөгжилд түлхэц өгөх хамгийн чухал зорилт. 830 гаруй жил монголчуудыг өлсгөж даруулаагүй авч ирсэн зүйл бол мал аж ахуй. Монголын ирээдүйн хөгжил зөвхөн хөдөө аж ахуй дээр суурилж хөгжих ёстой. Мал аж ахуй дээр суурилсан үйлдвэржилтийг илүү хөгжүүлэх ёстой. Малчдын хөдөлмөрийг илүү өндөр үнэлж, малаас гарах түүхий эдийн үр шимийг хүртэх бодлогыг хэрэгжүүлэх учиртай. Монгол хүн яагаад үнэгүй сурч болохгүй гэж. Ийм нухацтай нарийн зүйлсийг тооцоо судалгаатайгаар гаргаж тавьж байгаа нь зөв.

МАХН-ын дарга, Монгол Улсын гурав дахь Ерөнхийлөгч Н.Энхбаяр арга хэмжээг хааж хэлсэн үгэндээ "МАХН 2016 оны сонгуульд оролцохдоо том зорилтууд тавья гэж шийдсэн. Эрдэмтэдтэйгээ хамт, тэднийхээ санаа бодлыг тусгаж эрдмийн зөвлөл байгуулж байгаад мөрийн хөтөлбөрөө боловсруулсан. Иргэд хэрэгжих эсэхийг асууж, эрдэмтэд тооцоо судалгаа хийгээд хэрэгжих бүрэн боломжтой гэж үзсэн байна. Сонгуульд орохдоо намууд мөрийн хөтөлбөрөө хөндлөнгийн аудитын байгууллагаар шалгуулж дүгнэлт гаргуулдаг. Энэ жишгийн дагуу бид хуулийн дагуу аудитын байгууллагаар шалгуулсан. Би Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байхдаа "Монгол Улсын үндэсний хөгжлийн стратеги" гэсэн бичиг баримтыг эрдэмтдийн багтай хамтран гаргаж байсан. Тухайн үед иймэрхүү л том зорилтууд бичигдсэн байсан. Харамсалтай нь манай улс эрдэмтдийнхээ санаа бодлыг хэрэгжүүлэхийнхээ оронд саармагжуулдаг улс төрийн буруу соёл байдаг учраас зорилгодоо хүрч чадаагүй. Өнгөрсөн хугацаанд улстөрчид дэндүү их ноёлолоо. Одоо эрдэмтдийнхээ санаа бодлыг сонсох цаг болсон. Бид ард түмнийхээ дэмжлэгийг аваад зорилтуудаа хэрэгжүүлж эхлэхэд эрдэмтэд хажуугаас хянана, шаардана. Бас зөвлөгөө өгч санал бодлоо уралдуулна. Улс төрийн намуудаас анх удаа мөрийн хөтөлбөрөө эрдэмтдийнхээ хяналтад өгч хэрэгжүүлэхэд хамтран ажиллах нөхцлийг үүсгэж байгаадаа баяртай байна. Монгол Улсын хөгжил дэвшил улс орны үндэсний аюулгүй байдлын баталгаа. Эрдэмтэд дуугүй байгаа газар улс орны аюулгүй байдал тусгаар тогтнол алдагддаг. Хүчтэй дуугарч байгаа цагт хөгжил дэвшил баталгаатай болдог нь бүх дэлхийн хөгжил дэвшлээс харахад батлагдаж байна. Өнөөдрийн үйл ажиллагаа бол эрдэмтэд улс төрийн намууд төрийн байгууллагууд орчин үеийн шаардлагад нийцүүлэн соёлтой хамтран ажиллах , нэгнийгээ хянах сайхан үйл ажиллагааны эхлэл боллоо гэж бодож байна. Мөн ард түмэнд мөрийн хөтөлбөр бодитой хэрэгжих үндэс баталгаа болж байна гэж ойлгогдож байгаа байх" гэдгийг онцоллоо.

ДУУЛИАНЫ ЭРГЭН ТОЙРОНД

## ЭРХ МЭДЛИЙН ТӨЛӨӨ ЭВЛҮҮЛЭГ ХҮРТЭЛ ХИЙДЭГ БОЛЖ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Болоогүй, мордохын хазгай гэгчээр УИХ-ын сонгуулийн гуравдугаар тойрогт АН-аас өрсөлдөж буй Р.Гончигдоржийн ухуулагч нь шал согтуу машин барьж яваад айлын тугал дайраад алчихаж. Улмаар, дайрснаа ч сөхөөрөх тэнхэлгүй машин дотроо хурхиран унтаж байгаа бичлэг өнгөрсөн амралтын өдрүүдээр сошиал орчинд нэлээдгүй тархлаа.

Дээрх жишээнээс үзвэл энэ удаагийн сонгууль юм юмтай л сонгууль болох нь. Сурталчилгаа дөнгөж эхэлмэгц П.Анужин руу баахан дайрсан. Бүр "Секс хийж байгаа бичлэг ил боллоо" гэсэн гарчигийн дор нэр нүүрийг нь барах гэсэн ч бүтэлгүйтсэн. Холбогдох байгууллагууд цацагдсан бичлэгийг шалгаж үзээд эвлүүлэг байна гэдгийг нь тогтоогоод нэр бүхий хэдэн цахим хуудсыг хаасан. Тэгвэл МАН-ын удирдлагуудын аудио бичлэг эвлүүлэг болох нь тогтоогдвол АН хийгээд анх гаргаж тавьсан хүмүүс нь хүнд байдалд орно. МАН-ын нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалангийн яриагаар бол хэд хэдэн удаагийн уулзалтаас эвлүүлж гаргасан бичлэг хэмээн мэдэгдсэн. Мөн холбогдох байгууллагуудад шалгуулахаар өгснөө ч дуулгасан. Харин нөгөө талд өр, зээл хоёр ижил утгатай гэдгийг ойлгодоггүй З.Энхболд МАН-ын нэр бүхий гурван хүнийг АН-аас уучлал гуйхыг шаардсан.

АН-ынхан эрх мэдлийн төлөө улайран зүтгэж байна. Тэд ялж л байвал юу ч хамаагүй хийж байна, хийхээр ч төлөвлөж байна. Эцэс сүүлдээ яриагүй зүйлийг ярьсан болгож, хийгээгүй юмыг хийсэн болгож аудио бичлэг хүртэл эвлүүлж өрсөлдөгчөө муухай харагдуулахыг хүсч байна. Тэдэнд үүнээс өөр хийж чадах зүйл байхгүй. Ард түмэн итгээгүй биш итгэсэн. Харин итгэсэн итгэлийнх нь хариуд ус цацчихаад "Уучлаарай" ч байхгүй, хамаг бурууг өрсөлдөгч намдаа наах гэж оролдож байгаа нь арай л "богино зайн" улс төр үү, үгүй юу. Юутай ч сонгуулийн сурталчилгаа өнөөдөр 00.00 цагт дуусна. Монголчууд 2012 онд АНдуурсан сонголтоо зөв болгож МАНдуулах сонголт болгох цаг ч дөхөж байна даа...

## МЭДЭГДЭЛ

2016 оны УИХ-ын сонгууль хүч тэнцвэргүй, өнгө мөнгөний сонгууль болох гэж байгаа нь улам бүр тодорхой болсоор байна. Тухайлбал, "Бид зүтгэнэ, Хамтдаа хөгжинө" гэсэн уриатай оролцож байгаа МАН нь төрийн албыг үнэлэн наймаалцах замаар 60 тэрбум төгрөг босгож сонгуулийн зардлаа бүрдүүлснийг гэрчлэх бичлэг баримт ил болсон нь үүнийг гэрчилж байна.

Энэ нь сонгуулийг хандиваар биш төрийн албыг наймаалцсан авлига, хээл хахуулийн аргаар явуулж, төрийн эрхийг хууль бусаар, мөнгөөр худалдаж авах гэсэн санаатай үйлдэл гэж үзэхээр байна. Мөн төрийн албан хаагчдыг мэргэжил, ур чадварыг нь үл харгалзан олноор нь халж сольж, ах дүү хамаатан садан, танил тал, тойрон хүрээлэгч, цүнх барьдаг хүмүүсээ албан тушаалд томилж, төрийн албыг гэр бүлийн алба болгох гэсэн байдал харагдаж байна. Иймд МАХН-аас Ардын намын энэ үйлдэл нь цаашид төрийн алба тогтворгүй болох, Монгол төрийг хүчгүйдүүлэх хортой үр дагаварт хүргэхээс сэрэмжлүүлж байна.

Улс төрийн намууд Сонгуулийн хуульд заасны дагуу 4.6 тэрбум төгрөгийн хүрээнд сонгуулийн сурталчилгаагаа явуулах эрхтэй. МАХН Сонгуулийн хуулиа мөрдөн ажиллаж байна. Гэтэл Ардын нам, мөн тус намаас нэр дэвшигчид нь хөрөнгө мөнгөөр илт илүүрхсэн байдалтай сурталчилгаагаа явуулж байгаа нь сонгуулийн зардлаа 10 дахин хэтрүүлж 60 тэрбум төгрөг босгосонтой нь холбоотой гэж үзэж байна.

Иймд МАХН-аас МАН-ыг улс төрийн соёлтой байж, ард түмнээ хүндэтгэж, нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, Монгол Улсын хэмжээнд тогтоосон хууль дүрэм, ёс суртахууныг дээдэлж, шударга ёсыг сахиж, цэвэр шударгаар өрсөлдөхийг уриалж байна. Мөн сонгуулийн хууль зөрчсөн аливаа хэрэг зөрчил, шударга бус зүйлийн эсрэг хамтарч ажиллахыг бусад улс төрийн нам, хүчнүүдэд хандан уриалъя. 2016 оны УИХ-ын болон аймаг, дүүргийн НИТХ-ын сонгуулийг хуулийн дагуу шударга явуулах нөхцөлөөр хангаж ажиллахыг СЕХ, Цагдаа, Прокурорын байгууллагаас шаардаж байна.

**МАХН-ЫН СОНГУУЛИЙН ТӨВ ШТАБ**

ӨӨР ӨНЦӨГ

## ҮҮЛТЭЙ УЛААНБААТАРТ ХӨГЖЛИЙН ХУР ОРНО

Х.ГАРЬД

"Хагдарч" явсан Улаанбаатар дөрөвхөн жилийн өмнөөс "халиурч" эхэлсэн. Үүлтэй болсон Улаанбаатарт хөгжлийн хур бууж, бүтээн байгуулалтын "бослого" гарсан он жилүүд үргэлжилж байна. Гэр хорооллын хорт яндангууд эхнээсээ багасч, зам талбай сунгаж татсан гортиг шиг хүрээгээ тэлж, гэрэлтүүлэг, орон сууц, шинэ сургууль, цэцэрлэг борооны дараах мөөг шиг олширчээ. Түгжрэлгүй зам, түгжээгүй төрийн үйлчилгээ, стрессгүй амьдрал, эрүүл орчин. Энэ бүгд нийслэлчүүдийн зөв сонголтын үр шимд дөрөвхөн жилийн дотор бий болсон зүйлүүд юм.

Одоо харин нийслэлчүүд Э.Бат-Үүлийн багтай хамтарч өөрсдийн бүтээсэн энэ их ажлаа урагшлуулах уу, ухраах уу гэдэг сонголтын заагт тулж ирээд байна. Ухрах уу, урагшлах уу?

Хөгжлийн хөдөлгүүр эрчээ авбал хэрхэн урагшилдгийг бид өнгөрсөн дөрвөн жилд хангалттай харлаа. Харин ухарвал яах бол, хөгжлийн хөдөлгүүр унтарвал хэрхэх бол. Биднийг ямар ирээдүй, ямар Улаанбаатар угтаж байгаа бол.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим орчинд Э.Бат-Үүл болон түүний багийнхны хийсэн бүхнийг харлуулах, гутаах, доромжлох зохион байгуулалттай ажиллагаа хүчтэй явж байгаа. Сүүлдээ тэд Э.Бат-Үүлийг хотын хөгжлийг урагшлуулсан нь буруу мэт мэдээлэл гаргаж, түүний хийснийг засна, өөрчилнө гэх зэргээр явуургүй ухуулга хийж эхэллээ. Тэгвэл үнэхээр Үүлгүй Улаанбаатар ямар байх бол. Төсөөлөөд нэг үзье.

### ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ ЗОГСЧ, ИРГЭД ӨЛСГӨЛӨН ЗАРЛАНА

Нийслэлийн ИТХ-аар Гэр хорооллын дахин төлөвлөлт төслийг зогсоосноо зарлаж, гүйцэтгэгч 40 орчим компанийн гэрээг цуцална. Ингэснээр орон сууцанд ороод буй мянга мянган иргэний араас энэ онд багтан шинэ байрны түлхүүрээ авахаар хүлээн суугаа мянга гаруй иргэн Төв талбайд гарч хэрүүл зарга үүсгэн, өлсгөлөн зарлахад хүрнэ.

### "САЙН ХАШАА" НУРНА

Барилгын ажил эхэлсэн ч гэр хорооллын дахин төлөвлөлт, "Сайн хашаа" хөтөлбөрийг зогсоосноор орон сууцны нэг ч ажил эхлэхгүй. Жижиг бизнес хумигдаж, ажилгүйдэл газар авна. Хашааны газраа байраар солих хөтөлбөр бүрэн зогссоны улмаас энэ төслийг санхүүжүүлж байсан банк дампуурлаа зарлана. Ингэснээр эдийн засгийн маш хүнд, дааж давшгүй хямрал нүүрлэх юм.

### ГАЗАР ОЛГОЛТ ГАРЫН ҮСГЭЭР ЯВАГДАНА

Нийслэлийн газар олголтын асуудлыг хариуцаж байсан, муу нэртэй хуучин дарга Улаанбаатар хотын мээр болно. Ингэснээр нийслэлийн үнэт газрууд өмнөх шигээ зөвхөн хотын дарга болон дүүргийн хэдэн дарга нарын гарын үсгээр л олгогдож эхлэх юм. "Зүтгэл, итгэл, сэтгэл-Эх орон" ТББ-ын гаргасан "Газраа алдвал бүхнээ алдана" үзэсгэлэнгээс харахад л өмнө нь ямар шударга бус зүйлүүд явж байсныг мэдэж болно.

### ОЛОН МЯНГАН ИРГЭН АЖИЛГҮЙ БОЛНО

Хот, дүүргийн тамгын газар, хэлтсийн ажилтнуудаас эхлээд автобусны жолооч, тохижилт үйлчилгээний цэвэрлэгч хүртэл олон мянган ажилтан улс төрийн шалтгаанаар ажилгүй болно. Сүүлд олон нийтэд цацагдсан МАН-ын удирдлагуудын нууц дуу бичлэг үүнийг нотолж байна.

### "72 МЯНГАН ИРГЭН ЖАГСАНА"

Цахим газар өмчлөл зогсоно. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүлийн үед цахимаар газар өмчилсөн 72 мянган иргэн хотын захиргааны өмнө жагсч, энэ үймээн олон өдрийн турш үргэлжилнэ. Эцэст нь иргэд биш эрх мэдэлтнүүд ялна.

### НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮҮДЭЭ ХААНА

АН-ын үед гаргасан иргэдийн амьдралд асар их хэрэгтэй шийдвэрүүдийг хянаж, буцааж, бүртгэлийг шинэчлэх үргүй их ажлыг хийж дийлэхгүйн улмаас "Дүнжингарав", "Мишээл экспо", "Драгон" төв дэх нийслэлийн нэг цэгийн үйлчилгээний ажлыг зогсоохоос гадна ТҮЦ машин ачааллаа дийлэхээ болино. Хүнд суртал эргэн ирнэ.

### ТҮГЖРЭЛ ИХЭСЧ, СТРЕСС НЭМЭГДЭНЭ

Дугаарын хязгаарлалт үйлчлэхээ больж, хуучин хар түүх эргэн ирж, түгжрэл, стресс, хэрүүл газар авна. Түүгээр барахгүй нэгдүгээр эгнээгээр нийтийн тээврээр иргэд биш, эрхтэн дархтанууд том машинаараа тоос татуулан давхина. Тийм захирамж хүртэл гарна.

### УХААЛАГ АВТОБУС "ТЭНЭГ" БОЛНО

Хөрөнгө оруулалт байхгүй гэх нэрийн дор улс төрийн шалтгаанаар ухаалаг автобус үгүй болно. Шахдалцсан, халаасны хулгай гарсан, хүйтэн, бохир автобус бий болж, кондукторууд ажилдаа эргэн орно.

### ХАРАНХУЙ ХОТ

Гэр хороололд битгий хэл хотын төвд шинэ гэрэлтүүлгийн ажил хийгдэхээ болино. Харанхуй хот бий болж, гэмт хэргийн гаралт үлэмж нэмэгдэнэ. Цагтаа АСЕМ-ийн зохион байгуулж, зам тавьж, гэрэл нэмж, өндөр өндөр барилга сүндэрлэж байсан Улаанбаатар хот эргэн "Утаанбаатар" болж, хогондоо баригдаж, авлига хээл хахууль идэгдсэн хот болно.

Тэгвэл нийслэлчүүд бид үнэхээр ирээдүйн Улаанбаатарыг ийм байгаасай гэж хүсч байгаа гэж үү. Үгүй. Аз жаргалтай, эрүүл амьдралын төлөө Урагшилж эхэлсэн Улаанбаатарыг улам урагшлуулах хэрэгтэй. Үүлтэй Улаанбаатарт хөгжлийн хур орно. Урагшилна.

# ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронд

# ШҮҮХЭД өгнө, ХУУЛИЙНХАНД хандана

УИХ-ын ээлжит сонгууль болж, ард түмэн сонголтоо хийхэд ердөө хоёрхон хоног үлдээд байна. Сонгуулийн өдөр ойртох тусам нэр дэвшигчдээ сурталчилгаа эрчимжиж, цаашлаад бие биенийхээ эсрэг хийх хар муу бүхэн ч нэмэгдэж байгаа юм. Тэгвэл "Монголын мэдээ" сонин энэ удаагийн "Онцлох хуудас"-аараа дамжуулж, сонгуулийн хууль зөрчсөн гэж мэдээлсэн, цаашлаад шүүхэд өгөхөөр болсон тохиолдлуудыг онцолж байгаа юм.

## ХҮН-ЫН БИЕ ДААГЧ ХУУЛЬ ЗӨРЧСӨНИЙГ ШҮҮХ ТОГТООЖЭЭ

**2015.06.26:** УИХ-ын сонгуулийн 58 дугаар тойрогт бие даан нэр дэвшигч Д.Гантулга Сонгуулийн хуулийн хэд хэдэн заалт зөрчсөнийг намынх нь үүрийн дарга илчилж хуулийн байгууллагад хандсан асуудал анхан болон давж заалдах шатны шүүхээр шийдэгдсэн байна. ХҮНамын Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны 16 дугаар үүрийн дэд дарга Р.Эрдэнэбат УИХ-ын сонгуулийн 58 дугаар тойрогт бие даан нэр дэвшигч Д.Гантулгыг Сонгуулийн хууль зөрчсөн хэмээх гомдол гаргаж цагдаагийн байгууллагад ханджээ. Уг гомдолд дурьдсанаар нэр дэвшигч Д.Гантулга сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө буюу 2016 оны тавдугаар сарын 22-ны өдөр Хан-Уул дүүргийн нэр бүхий 50 хүнийг "Домогт мэлхий хад" амралтад амрааж, уралдаан тэмцээн зохион байгуулж ялсан багийг нэг сая төгрөгөөр шагнаж, бусад багуудад 200 мянган төгрөг өгчээ. Улмаар "Би сонгуульд ялбал та нарт тус бүр нэг сая төгрөг өгнө" гэж амласан байна. Түүнчлэн дэмжигчийн гарын үсэг цуглуулсан хүмүүст 250 мянган төгрөг өгч, зургадугаар сарын 1-нд дээрх 50 хүний хүүхдүүдэд бэлэг тараажээ.Бэлэн мөнгө, бэлэг тараасан, мөнгө амласан, нийтийн хамарсан амралт зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулж ивээн тэтгэсэн зэргээр Сонгуулийн тухай хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн энэхүү асуудлыг цагдаагийн байгууллага шалгаж тогтоогоод шүүхэд шилжүүлсэн байна. Анхан шатны шүүхээс Д.Гантулга хууль зөрчсөнийг тогтоосон шийдвэр гарсан бөгөөд хариуцагч талын гомдлоор давж заалдах шатны шүүх хянан хэлэлцээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.Одоо Сонгуулийн ерөнхий хорооноос хууль зөрчсөн нэр дэвшигчийн нэрийг эргүүлэн татах асуудлаар шийдвэр гаргах юм байна.

## Л.ЭРДЭНЭЧИМЭГ: БИ ЦАГДААД ГОМДОЛ ГАРГАСАН

**2016.06.15:** УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэгийн төрийн ордонд тамхи татаж байгаа бичлэгийг өрсөлдөгч нар нь хэвлэлээр тараасан. Түүний дараа эрхэм гишүүн тайлбар хийсэн билээ. Тэрбээр "Х.Бат-Ялалт зургадугаар сарын 6-ны өдөр над руу залгаж, миний төрсөн өдрөөрөө вино уусан бичлэгийг үзүүлж, 200 сая төгрөг нэхсэн. Би энэ бичлэгийг үзээд, миний төрсөн өдрөөр Г.Уянга гишүүний авсан бичлэг болохыг мэдсэн. Тэгээд Г.Уянга гишүүн рүү залгаад, ямар учиртай, яагаад бичлэг алдагдсан болохыг лавлахад би гар утсаа хулгайд алдсан, энэ асуудлаар Чингэлтэй дүүргийн цагдаагийн газарт гомдол гаргасан. Та ч бас энэ асуудлаар Чингэлтэйн цагдаад хандаарай гэсэн. Энэ дагуу зургадугаар сарын 7-ны өдөр гомдол гаргасан. Би энэ явдлыг маш нарийн, эртнээс төлөвлөсөн явдал гэж харж байгаа. Учир нь Тосонбумын нурууг тусгай хамгаалалтад авахуулсан Оюунгэрэл та хоёр 50 тэрбумыг төлөөрэй гэж байнга утсаар дарамталдаг. Энэ мөнгөтэй улсуудын гар хөл нь Х.Бат-Ялалт, Т.Алтаншагай нар юм байна гэж би хардаж байгаа. Тиймээс Т.Алтаншагай зориуд надтай нэг тойрогт өрсөлдсөн байх. Ер нь эмэгтэй нэр дэвшигчид рүү дайрч байгаа байдал хэрээс хэтэрлээ. М.Нарантуяа, П.Анужин нар луу яаж дайрлаа, одоо хэн дээр ээлж нь ирж байгааг та бүхэн харж байгаа байх" хэмээн ярьсан юм.

## З.БАЯНСЭЛЭНГЭ: Н.УЧРАЛЫГ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДААР ШАЛГУУЛНА

**2016.06.23:** УИХ-ын сонгуулийн 72 дугаар тойрогт МАХН-аас нэр дэвшигч З.Баянсэлэнгэ МАН-аас энэ тойрогт нэр дэвшин өрсөлдөж буй Н.Учралыг хууль хяналтын байгууллагаар шалгуулахаа мэдэгдэж, хэвлэлийн хурал хийсэн билээ. Тэрбээр "Намайг "садар самуун явдалтай хүүхэн" гэж бичсэн байна лээ. Намайг гүтгэх, доромжлох энэ үйл ажиллагааг Н.Учрал зохион байгуулж байна гэж үзэж байгаа учраас холбогдох байгууллагуудаар нь шалгуулна. Би өдийг хүртэл дуугүй л байсан. Оюутнуудын сургалтын төлбөрийг тэрбум тэрбумаар нь цацаж байгаа хүүхэдтэй юм ярьж доошоо ороод яах вэ дээ гээд чимээгүй явсан. Сонгуулийн өмнө тойрог хуваарилах үеэр Н.Учрал надтай ирж уулзсан. Тэгээд "Баянсэлэнгэ эгч ээ, та санал хуваах хэмжээний хүн биш ээ. Та төрд байх ёстой хүн. Тийм учраас би таныг тойргоо солиод өгөөч ээ" гэж гуйсан. "Та тойргоо сольчихвол Л.Эрдэнэчимэгийг амархан ялчих гээд байна. Та тойргоо сольчихвол би танд сурталчилгаанд явах оюутан өгье. Надад гурван телевиз байна. Телевизээсээ танд өгий" гэж хэлсэн. Би "Үгүй ээ. Намын шийдвэр учраас тойргоо солихгүй" гэж хэлээд явуулсан. Би шударгаар өрсөлдөх гээд гүйж явна" хэмээсэн юм.



## Н.НЯМ-ОСОР: Н.УЧРАЛЫГ ГҮТГЭСЭН САЙТЫГ ШҮҮХЭД ӨГНӨ

**2016.06.15:** Сонгинохайрхан дүүргийн 72 дугаар тойрогт АН-аас нэр дэвшч буй Л.Эрдэнэчимэгийн Төрийн ордонд тамхи татаж бичлэгийг сэтгүүлч Т.Алтаншагай, шударга шүүгч гэгддэг Х.Бат-Ялалт нар цахим ертөнцөөр тараасан билээ. Уг бичлэгийг УИХ-ын гишүүн Г.Уянга бичиж авсан гэх. Үүнийг нь Х.Бат-Ялалт 50 саяар Л.Эрдэнэчимэгт зарсан гэх мэдээлэл ч гарч байсан. Энэ мэт хардлага сэрдэлгийн хажуугаар Сонгинохайрхан дүүрэгт МАН-аас нэр дэвшч буй Н.Учралыг уг хэрэгт холбоотой, бүр 200 сая төгрөг хувиасаа гаргаж Г.Уянгад өгсөн гэх мэтийн хардлага цахим ертөнцөөр тухайн үедээ явж байсан юм. Тэгвэл Н.Учралын аав Н.Ням-Осор өгүүлэхдээ "Учралыг гүтгэн доромжлох явдал хэрээс хэтэрлээ. Уянгад 200 сая төгрөг өгч Л.Эрдэнэчимэгийн ёс зүйгүй бичлэгийг худалдаж авсан гэж гүтгэн доромжилж байна. Манай хүү тэр Уянгад 200 сая төгрөг өгч бичлэг авах нь байтугай түүнийг таних ч үгүй, уулзаж ч үзээгүй. Миний хүү ийм хөгийн юманд хутгалдах хүн хэрхэвч биш. Ингэж ор үндэсгүйгээр гүтгэн доромжилсон явдлыг бид няцааж байна. Тиймээс бид гүтгэлэгийг анх тараасан "Монгол мессенжер" сайтыг шүүхэд өгнө" хэмээсэн юм.

## Д.ЗОРИГТЫГ ГҮТГЭСЭН МЭДЭЭЛЛИЙГ ШАЛГУУЛАХААР ЦАГДААД ГОМДОЛ ГАРГАЖЭЭ

**2016.06.22:** УИХ-ын сонгуулийн Баянзүрх дүүргийн 49 дүгээр тойрогт нэр дэвшигч Д.Зоригтын сонгуулийн штабаас Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэст албан ёсоор гомдол гаргаж, шүүх цагдаа болсон юм. Тухайлбал, Нэр дэвшигч Д.Зоригтыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гүтгэж оффшор данстай гэх мэдээлэл ойрын өдрүүдэд гарсан. Тухайлбал, нэр дэвшигч Д.Зоригтыг "Зууны мэдээ" сонины 2016 оны зургадугаар сарын 09-ний өдрийн 115 (5301) дугаарт "Санхүүгийн, сонгуулийн голдуу асуудалтай Д.Зоригт сайд" гэх нэртэй нийтлэлд Д.Зоригтын нэр төрд нь халдаж, 2012 оны УИХ-ын сонгуулийг луйвардаж авсан, мөн гадаад улсад оффшор данстай, компанитай хэмээн гүтгэсэн мэдээллийг сонгогчдод сонгуулийн сурталчилгааны явцад сонин, цахим хуудас, вэб сайтаар удаа дараа тараасан болно. Мөн зарим хувь хүн өөрийн файсбүүк хаяг дээрээ оффшорчин Д.Зоригт, УИХ-ын 2012 оны сонгуулийг луйвардсан гэх мэтээр гүтгэлэг агуулсан мэдээллийг олон нийтэд санаатайгаар тарааж байгаа тул цагдаагийн байгууллагад шалгуулахаар болжээ. Энэ нь "Сонгуулийн тухай хууль"-ийн 70 дугаар зүйлийн 70.1.6 дэх хэсэгт зааснаар "...хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орон зай, мессеж ашиглан ... бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах.." гэж заасныг удаа дараа ноцтой зөрчиж байна" хэмээжээ. Бас л нэг шүүх, цагдаагийн асуудал.

## Су.БАТБОЛД: Л.ЭРХЭМБАЯРЫГ ШҮҮХЭД ӨГСӨН

**2016.06.21:** УИХ-ын гишүүн Су.Батболд Тусгаар тогтнолын ордонд иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар мэдээлэл хийсэн билээ. Сүүлийн үед иргэний шилжилт хөдөлгөөн эрчимжиж, зарим аймгууд руу бүр 3000 гаруй иргэд шилжсэн тухай мэдээлэл цацагдсан. Энэ асуудлыг МАН-тай холбож байгаа нь хууль бус гэдгийг илэрхийлж, хурал хийсэн юм. Тэрбээр "МАН-ын зүгээс Бүртгэл статистикийн газраас мэдээлэл авсан. Тус газраас өгсөн мэдээллээр сүүлийн нэг сарын хугацаанд Монгол Улсын хэмжээнд 18 мянга гаруй сонгогч шилжилт хөдөлгөөн хийлгэсэн байна. Тухайлбал, Архангай аймагт 1341, Баянхонгор аймагт 2059, Дархан-Уул 694, Дундговь аймагт 772, Завхан аймагт 600, Сэлэнгэ аймагт 631, Увс аймагт 3237 сонгогч, Төв аймагт 826, Ховд аймагт 717, Хөвсгөл аймагт 2943, Өвөрхангай аймагт 897 сонгогч тус бүр шилжиж, нийт дүнгээр 17189 сонгогч шилжиж очжээ. УИХ-ын сонгууль нэг мандат нэг тойрог гэсэн зарчмаар буюу 76 жижиг можаритор тогтолцоогоор явагдаж байгаа. Сонгуулийн тойрогт дунджаар 25 мянга орчим сонгогч оногдож байгаа. Гэтэл сонгуулийн үеэр ийм их шилжилт хөдөлгөөн хийгдсэн нь сонгогчдын дунд нөлөөлөх асуудал үүсгэж байна. Тиймээс манай намын Сонгуулийн төв штабаас нэлээд санаа зовж байгаа. Бүртгэл статистикийн төв газар, СЕХ болон бусад газруудад олон тооны мэдэгдэл явуулсан. Сонгогч уг нь өөрийн биеэр очиж шилжилт хөдөлгөөн хийлгэх ёстой. Гэтэл нэг хүн 100 орчим хүний иргэний үнэмлэх авч очиж шилжилт хөдөлгөөн хийлгэж байгаа асуудал гарч байна. Төв аймгийн 30 дугаар тойрогт нэг шөнийн дотор 400 гаруй сонгогчдыг бүртгүүлсэн зөрчил гарсан. Гэртээ унтаж байхад нь дуудаж аваачаад бүртгүүл хэмээн шахаж шаардсан зөрчил гарлаа. Энэ бүхнийг баталгаажуулж хууль хяналтын байгууллагад өгөхөөр болж байна. Мөн АН-ын зүгээс мэдээлэл хийхдээ сонгогчдын шилжилт хөдөлгөөнийг МАН-ын гишүүд хийсэн мэтээр ойлгуулсан учраас энэ асуудлыг шалгуулахаар Л.Эрхэмбаяр генсекийг шүүхэд өгсөн" хэмээлээ.

Сэтгүүлчийн өнцөг

# ЗУНЖИНГАА Л ШҮҮХДЭЛЦЭХ НЬ ДЭЭ

...Сонгуулийн дараа ялагдалтайгаа эвлэрэхгүй хүмүүс хэдэн арвааараа гарч ирнэ. Хар машин буруу тоолсон. Хяналтын тооллого хийхдээ том намууд луйвардсан. Жижиг нам, бие даагчдын төлөөлөл, хяналт сул байгаа...

Н.ПУНЦАГБОЛД

Дээрх тойрогт сонгуулийн өмнө бие биенийгээ хэрхэн шүүх цагдаа, хууль хяналтын байгууллагад өгч байгаа хүмүүсийг зах зухаас нь дурьдлаа. Үүнээс гадна Т.Алтаншагай мэдэгдэл гаргаж, өөрийнхөө тараасан бичлэгтэй холбоотой асуудлаар хүмүүсийг шүүхэд өгч байгаагаа ч зарласан билээ. Ер нь шүүхэд өгч байгаа тохиолдлуудыг тоочоод барамгүй. Зарим нэр дэвшигч сонгуулийн хууль зөрчиж, иргэдэд архи, мөнгө тараасан, бэлэг сэлт өгсөн гэх асуудал ч босч ирж байна. Мэдээж энэ бүхний цаана дахиад л шүүх, цагдаа болно. Бүр ганц нэг хүн хууль зөрчсөн үйлдэл нь тогтоогдсон учраас нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтаас хүртэл хасагдчихлаа. Сонгуулийн сурталчилгаа ч халуухан өрнөж байна. Бие биенээ харлуулах гэсэн ажлаа ч бүх нэр дэвшигчид, нам, эвслүүд чадлынхаа хэрээр хийж байгаа.

Цаашлаад өнөөх үйлдлээ зарим нь батлах гэж, нөгөө хэсэг нь эсэргүүцэх гэж хэрэндээ л "дайн" хийж эхэллээ. Энэ бүхний эцэст дахиад л цагдаа, хууль, шүүх. Одоо нэгийгээ шүүхэд өгөөгүй, цагдаад гомдол гаргаагүй нэр дэвшигч, нам эвсэл, улс төрийн хүчин гэж байхгүй боллоо. Хамгийн сүүлд СЕХ-ноос авсан мэдээллээр 700 хол давсан гомдол цагдаад ирчихсэн байгаа юм билээ. УИХ-ын сонгуульд 497 нэр дэвшигч өрсөлдөж байгаа. Гэтэл цагдаад 700 гаруй гомдол ирээд, түүнийг нь шалгаж байгаа гэх. Ингэхээр цагдаад нэр нь очоогүй, гомдол гаргуулаагүй хүн үлдэв үү, ер нь. Энэ янзаараа монголчууд бид зуны гурван сар нэг нэгнээ шүүхэд өгсөн хэдэн улстөрч нэртэй нөхдүүдийн хэрүүлээс өөр зүйл үзэж, харах нь уу. Азаар наадам болоод, дараа нь Олимп залгах юм байна даа. Гэхдээ уг нь сонгуулийн дараа хурдан засаг төрөө бүрдүүлээд, ажлаа эхлээд, ард түмэн, улс орныхоо амьдралыг өөд нь татах ажилдаа ханцуй шамлан орвол сайнсан. Гэвч тэгэхгүй нь бололтой. Сонгуулийн дараа ялагдалтайгаа эвлэрэхгүй хүмүүс хэдэн арвааараа гарч ирнэ. Хар машин буруу тоолсон. Хяналтын тооллого хийхдээ том намууд луйвардсан. Жижиг нам, бие даагчдын төлөөлөл, хяналт сул байгаа.

Гэх мэтээр ярих зүйл, гаргах шалтаг мундахгүй дээ. За цаашлаад хоёр том намын нэр дэвшигчид ч гэсэн шүүх, цагдаа дээрээ тулна, тодорхой. Өмнөх сонгуулиудад 2-3 тойрогт маргаан гарч, шүүх цагдаа болж байсныг мартаагүй л байна. Ерөнхийдөө уламжлал гэж хэлж болно. Бүр асуудлаа шийдэж чадахгүй жил тойрч болдог байлаа. Тэгвэл энэ жил түүнээс олон хүн гомдол гаргаж, шүүх цагдаа болох болов уу. Одоо байгаа янз байдлаас харахад шүү дээ. Ядаж байхад нэг тойрог дээр хэчнээн нэр дэвшигч байгаа билээ дээ. Тэр дундаа хотод. АН, МАН, МАХН-аас авахуулаад хэчнээн ч жижиг нам байгаа юм, бүү мэд. Ядаж байхад нэг тойрогт хамгийн багадаа нэг бие даагч. Цаашлаад хоёр, гурван хүн ч бий. Ийм байхад шүүхээс салахгүй гэдэг нь тодорхой байгаа юм. Дурлалын гурвалжин гэдэг шиг бие биенээ шүүхэд өгч байгаа ч тохиолдлууд гарч байгаа. Хөөрхий шүүх, цагдаагийнхан л жаахан зовох нь дээ. Дээрээс нь УИХ, Засгийн газар бүрдэхгүй намартай золгох вий дээ, бусад нь ч дүүрч.

ДЭЛХИЙ

# Их Британичууд




# ЕХ-Д "ҮГҮЙ" ГЭЖ ХЭЛЛЭЭ

Б.ДАВАА

Их Британичууд Европын холбоонд үлдэх, эс үлдэх гэсэн хоёр хариултын нэгийг дугуйлж, сонголтоо хийснээр ЕХ-ны байдал түгшүүртэй болж эхэллээ. Түүхэн гэж хэлж болохуйц санал асуулгад тэд "Гарах" сонголтыг хийсэн юм. Ингэснээр Их Британийн бүрэлдэхүүн улс Шотландын ирээдүй хийгээд санхүүгийн зах зээлд үүсээд буй шуурганы талаарх олон асуултууд урган гарч ирлээ. Тодруулбал, энэ сарын 23-ны өдрийн санал асуулгаар британичуудын 52 хувь нь гарах сонголтыг хийж, үлдсэн 48 хувь нь үлдэх гэсэн хариултыг дугуйлсан байлаа. Үндсэндээ дөрвөн сарын хугацаанд үлдэх, гарах гэсэн хоёр хэсэгт хуваагдан мэтгэлцэж байсан ард түмэн эцсийн шийдвэрээ ийн гаргалаа. Санал асуулгын дараагаас эхлэн фунт стерлингийн ханш 1985 оноос хойш хамгийн доод төвшинд хүрч унажээ. Санал асуулгын эхний үр дүн зарлагдмагц фунт стерлингийн ханш гурван хувиар унаж еврогийн эсрэг 6.5 хувиар суларсан байна.

> ...18-24 насны залуусын 70 гаруй хувь нь "Үлдэх" гэсэн хариултыг дугуйлсан байгаа бол 65 наснаас дээш насныхан "Гарах" сонголтыг илүүтэй дэмжсэн байжээ. Санал асуулгын хуудаст ердөө нэг асуулт бичигдсэн байв. "Та Их Британийг ЕХ-оос гарах эвсэл үлдэхийн алийг нь дэмжиж байна вэ" гэсэн асуултын дор "Үлдэх", "Гарах" гэсэн хоёр хариулт бүхий хуудсыг бөглөж, британичууд сонголтоо хийсэн юм...

Ямартай ч, британичууд гарах сонголтыг хийвэл фунт стирленгийн ханш огцом унаж, эдийн засагт эрсдэлтэй гэж зарим эдийн засагчид харж байна. Харин эсрэгээр ЕХ-ны санхүүгийн нөхцөл байдалд энэ удаагийн сонголт тийм ч ноцтой нөлөө үзүүлэхгүй бололтой. Их Британи эдийн засгийн хувьд ЕХ-ноос хараат бус гэж хэлж болохуйц тул холбооны эдийн засагт цохилт болохгүй гэж зарим ажиглагч үзэж байна. Харин тус холбооны эдийн засгийн үндэс суурь болж байгаа Герман, Франц, Испани гарлаа гэвэл холбоо нуран унах аюултай ажээ.

### Дэвид Камерон, Жонатан Хилл нар огцорлоо

Их Британи Европын холбооноос гарахаар болсонтой холбогдуулж тус улсын Ерөнхий сайд Дэвид Камерон мэдэгдэл хийлээ. Тэрбээр "Бид ирэх аравдугаар сард эхлэх Консерватив намын тэргүүлэх парламентад шинэ Ерөнхий сайдтай болох хэрэгтэй" хэмээжээ. Энэ үгээрээ тэрбээр Ерөнхий сайдын албан тушаалаасаа огцорч буйгаа мэдэгдлээ. Дэвид Камерон Европын холбооны гишүүн хэвээр байхыг тууштай дэмжиж байсан хүмүүсийн нэг юм. Европын холбооноос гарах санал дэмжигдвэл тэрбээр албан тушаалаасаа огцрох нь тодорхой болоод байсан билээ. Камероны ажлыг хэн үргэлжлүүлэх нь олон нийтийн анхаарлыг татаж эхэллээ. Үүнээс гадна Европын холбооны санхүүгийн удирдлагын асуудал эрхэлсэн комиссар 55 настай Жонатан Хилл ч мөн огцров. Тэрбээр ЕХ-ны гүйцэтгэх агентлаг болох Еврокомисст бүрэлдэхүүн орныг төлөөлөх 28 комиссарын нэг байжээ. Гэвч өнгөрөгч баасан гарагт Британийн санал асуулгын дүн гарсны дараа Жонатан огцорч буйгаа албан ёсоор мэдэгдсэн юм. Түүний хувьд Их Британийн Консерватив намын хүн бөгөөд 2014 онд тус албан тушаалд томилогдсон хэдий ч, санал асуулгатай холбоотойгоор албан тушаалаасаа огцорлоо.

### Словак, Италид ч санал асуулга болох уу

Их Британийн санал асуулгатай холбоотойгоор зарим ажиглагчид Европын холбоо задрах эхний алхам хийгдэж байгааг онцолж байсан юм. Гэхдээ зарим эдийн засагчид нэг их нөлөөлөхгүй гэх дүгнэлтийг хийжээ. Тэгвэл санал асуулгын дараа Словакийн хэт барууны үзэлтэй "Словакийн ардын нам" болоод Италийн сөрөг хүчнийхэн ЕХ-ноос гарах эсэх талаарх санал асуулга явуулах талаар үг унагаж эхлэв. Тодруулбал, "Словакийн ардын нам" энэ долоо хоногийн эхээр эрх баригчдаас дээрх асуудлаар бүх нийтийн санал асуулга явуулахыг шаардсан гарын үсэг цуглуулах үйл ажиллагааг эхлүүлэхээ мэдэгдсэн байдаг. Словакчуудын хувьд Ойрхи Дорнодын дүрвэгсдийн их урсгалд хатуу бодлого баримталдаг билээ. Харин Италид саяхан орон нутгийн сонгуульд Ром болон Турин хотын даргын суудлыг авсан "Таван од" хөдөлгөөнийхөн ЕХ-ноос гарах эсэх асуудлаар санал асуулга явуулах байр суурьтай байгаагаа илэрхийлж байна. Тус улсын Депутатуудын танхимын даргын орлогч, "Таван од" хөдөлгөөнөөс Ерөнхий сайдад нэр дэвших хамгийн магадлалтай байгаа Луижи Ди Майо энэ сарын 21-нд "Раи уно" телевизээр үг хэлэхдээ "Сөрөг хүчнийхэн Италийг евро бүсээс гаргах эсэх асуудлаар бүх нийтийн санал асуулга явуулах санаачилга гаргахаар шийдвэрлэлээ" гэж мэдэгдсэн байна. Италид бүх нийтийн санал асуулга ердөө хоёр удаа болж байжээ.

### Европын зургаан орны Гадаад хэргийн сайд нар ЕХ-той хэлэлцээр хийнэ

Британичууд ЕХ-ноос нүүр буруулах шийдвэр гаргасны дараа ЕХ-ны гол бүрэлдэхүүн гэгддэг Герман, Франц тэргүүтэй зургаан улсын Гадаад хэргийн сайдууд Берлинд шуурхай хуралдав. Улмаар уулзалтын төгсгөлд ойрын хугацаанд ЕХ-той хэлэлцээрийн ширээний ард суух шийдэлд хүрсэн байна. Энэ намар огцорно гэдгээ илэрхийлсэн Их Британийн Ерөнхий сайд Дэвид Камероны хувьд түүний залгамж болон сонгогдох шинэ Ерөнхий сайд ЕХ-той хийх хэлэлцээрийг хариуцах учиртай гэж мэдэгдсэн. Гэсэн хэдий ч, Герман, Франц тэргүүтэй орнууд үүсээд буй тодорхойгүй нөхцөл байдлыг хурдан хугацаанд дуусгавар болгож, яаралтай хэлэлцээр хийхийг Британиас шаардсан байна. Түүнчлэн, Германы Гадаад хэргийн сайд Франк-Вальтер Штайнмайер Британийн санал асуулгатай холбоотойгоор ЕХ-ны бусад бүрэлдэхүүн орнууд гарах хөдөлгөөнийг эхлүүлэхгүй байж, харилцан санал солилцохыг уриалсан мэдэгдэл хийжээ.

### Залуусын ихэнх нь "Үлдэх" сонголтыг хийв

Европын холбооноос гарах эсэх талаарх санал асуулгад оролцсон сонгогчдыг насны байдлаар нь ангилж үзвэл 18-24 насны залуусын 70 гаруй хувь нь "Үлдэх" гэсэн хариултыг дугуйлсан байгаа бол 65 наснаас дээш насныхан "Гарах" сонголтыг илүүтэй дэмжсэн байжээ. Санал асуулгын хуудаст ердөө нэг асуулт бичигдсэн байв. "Та Их Британийг ЕХ-оос гарах эвсэл үлдэхийн алийг нь дэмжиж байна вэ" гэсэн асуултын дор "Үлдэх", "Гарах" гэсэн хоёр хариулт бүхий хуудсыг бөглөж, британичууд сонголтоо хийсэн юм. Тэгвэл олон нийтийн санал асуулга явуулж ирсэн Консерватив намын сенатч асан Жон Эшкрофт дээрх үзүүлэлтийг гаргасан байна. Тэрбээр санал хураалт болсон өдөр 12400 хүнийг оролцуулсан судалгаа явуулахад "Үлдэх" сонголтыг хийсэн хүмүүсийн ихэнх нь залуус байсан гэнэ. Харин 55-64 насныхны 57 хувь нь, 65-аас дээш насныхны 60 гаруй хувь нь "Гарах" сонголтыг дэмжиж байжээ. Сонирхуулахад, эдүгээ Британид санал асуулгыг дахин явуулах эсэргүүцлийн хөдөлгөөн ч өрнөөд эхэлсэн сурагтай. Хоёр сая гаруй хүн одоогоор дахин санал асууга явуулахыг шаардан гарын үсгээ зурсан бөгөөд ЕХ-д үлдэхийг дэмжсэн хөдөлгөөн одоо ч өрнөсөөр байгаа ажээ. Нийтдээ 100 мянга гаруй хүн гарын үсэг зурсан тохиолдолд уг асуудлыг парламентаар хэлэлцэх эсэхээ шийдвэрлэх учиртай. Гэхдээ яг одоогоор дахин санал асуулга явуулах ямар ч боломжгүй гэдгийг эх сурвалж онцолж байгаа юм.

ОНЦЛОХ УЛС ТӨР

# "ГУРВАН НАЙЗ" ТҮҮХЭНД ШИНЭ ХУУДАС НЭЭЛЭЭ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Төрийн тэргүүнүүд юун түрүүн гурван улсын хооронд Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрөөс гадна зарим нэр төрлийн бараанд хийсэн гаалийн хяналтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Харин дамжин өнгөрөх тээврийн асуудлыг энэ удаад хойшлуулсан байна. Ямартай ч, Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг үзэглэсэн нь дэлхий нийтийн анхаарлыг татаж байгаа юм. Уулзалтын үеэр Хятадын дарга Си Зиньпин 2014 болон 2015 онд болсон гурван улсын төрийн тэргүүнүүдийн уулзалтын үр дүнг сайшааж, өнгөрсөн жил гэхэд Бээжингийн шинэ торгоны зам төсөлд оролцогчдод Хятадын компаниуд нийтдээ 15 тэрбум ам.долларын хөрөнгө оруулсан гэдгийг тодотгосон тухай "japant-imes" сонинд бичжээ. Мөн хөрш хоёр улсын тэргүүнүүдэд эдийн засгийн коридорыг байгуулж, тээвэрлэлтийн дэд бүтцийн холболт хамтын ажиллагааг бэхжүүлэх, боомтын бүтээн байгуулалт, аж үйлдвэрийн хүчин чадал, хөрөнгө оруулалт, худалдаа эдийн засаг, соёлын солилцоо, байгаль орчны чиглэлээр үр дүнд хүрэхэд хүчин чармайлт гаргахыг уриалсан байна. Харин манай улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж "Гурван талт хамтын ажиллагааны тохиролцоог бодит ажил хэрэг болгох зорилт ирж буй"-г онцолж, Эдийн засгийн коридорын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах асуудлын хүрээнд гурван талын холбогдох байгууллагууд хөтөлбөрт тусгагдсан 32 төслийн жагсаалтаас хэрэгжүүлэхэд бэлэн төслүүдийг тодорхойлж, эдгээр төслүүдэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэн хэрэгжүүлж, идэвхтэй ажиллах санал гаргасан байна. Мөн цаашид "Эдийн засгийн коридор" байгуулах хөтөлбөрт тусгагдсан төслүүдийг боловсруулах, тэдгээрийн эдийн засгийн үндэслэлийг тогтоох, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх үүднээс "Хөрөнгө оруулалт, төлөвлөлт"-ийн төв хэмээх механизм байх нь зүйтэй гэдэг дээр талууд санал нэгтэй байгааг харгалзан "Хөрөнгө оруулалт, төлөвлөлт"-ийн төвийг 2016 онд багтаан байгуулах саналыг дэвшүүлжээ.



Түүнчлэн "Төмөр замын төслүүдийг урагшлуулах бодитой механизм болох гурван талын Тээврийн асуудал эрхэлсэн яамд хоорондын төмөр замын асуудлаарх гурван талт зөвлөгөөнийг тогтмолжуулах хүсэлтэй байна. Гурав дахь удаагийн уулзалтыг энэ оны 8, 9 дүгээр сард Улаанбаатар хотноо хийж, тулгамдсан асуудлуудаа ярилцахаар төлөвлөж байна" гэжээ. Үүний хариуд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин "Жилийн өмнө Уфа хотноо болсон уулзалтаар бид хамтын ажиллагаагаа олон чиглэлд эрчимжүүлэхээр тохиролцсон. Гурван талын харилцааг улс төр, эдийн засаг, олон улсын харилцаа, соёл-хүмүүнлэгийн салбарт хөгжүүлэх Замын зураглал хэрэгжиж эхэлсэн нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Улс төрийн зөвлөлдөх механизм ажиллаж эхэлснээр бүс нутгийн анхаарал татсан асуудлуудаар байр сууриа уялдуулах сайхан боломж нээгдэж байна. Хил орчмын хамтын ажиллагааг бодитой эрчимжүүлэх гурван талын хөрөнгө оруулалтын 30 гаруй төслийг эхлүүлэхэд дээрх хөтөлбөр нь чиглэгдэж байгаа билээ. Төслийн хөрөнгө оруулалтын хамтарсан төв байгуулан уг хөтөлбөрийг бодитоор хэрэгжүүлэх талаарх Монголын талын саналыг ирээдүйтэй гэж үзэж байна. Тээврийн салбар, харилцаа холбооны шугам, цахилгаан дамжуулах шугам болон эрчим хүчний хангамжийн маршрутыг байгуулах салбарт хамтын ажиллагааны шинэ санал боловсруулахад дээрх төвийн үндсэн зорилт оршино. Оросын тал дэд бүтцийн санал, санаачилгад гол анхаарлаа хандуулах болно" хэмээсэн байна. Ямартай ч, Монгол Улсын төрийн тэргүүн Ц.Элбэгдорж улсын хөгжлийн түүхэнд шинэ хуудас, нэгэн шинэ түүхийг Узбекстаны Ташкент хотноо ийнхүү бичлээ. Дашрамд дурьдахад, гурван улсын төрийн тэргүүн дамжин өнгөрөх тээврийн асуудлыг энэ удаадаа хойшлуулсан ч, зарчмын хувьд тохиролцсон гэдгийг эх сурвалжууд онцолж байлаа.

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## ТҮРЭЭСИЙН МӨНГӨНӨӨСӨӨ БАЙРНЫХАА УРЬДЧИЛГААГ ТӨЛӨХ БОЛОМЖТОЙ

Н.БАТЗАЯА

*Монгол Улсын Засгийн газраас “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг баталсан. Тэгвэл энэхүү хөтөлбөрийн журам батлагдсанаар хөтөлбөр хэрэгжихээр боллоо. Уг хөтөлбөрийн талаар Нийслэлийн орон сууцны корпорацийн захирал Б.Тэлмэнгээс зарим зүйлийг тодруулав.*

**-“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн талаар танилцуулахгүй юу. Хэрхэн хэрэгжих юм бэ?**

-2015 онд Монгол Улсын Засгийн газар түрээсийн орон сууцны хөтөлбөрийг баталсан юм. Мөн 2014 онд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар нийслэлийн орон сууцны хөтөлбөрийг баталсан. Харин сая НИТХ-лын тэргүүлэгчдийн 123 дугаар тогтоолоор түрээсийн орон сууцны үйл ажиллагааны журам батлагдлаа. Энэхүү журам нь өөрийн гэсэн орон сууцгүй, тогтмол орлоготой боловч хуримтлал үүсгэн ипотекийн зээлд хамрагдаж чадахгүй байгаа зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцаар хангах зорилготой юм. Тэгэхээр уг хөтөлбөрт маань өөрийн гэсэн орон сууцгүй, тогтмол орлоготой иргэд хамрагдаж болно.

**-Энэ хөтөлбөр ТОСК-иас хэрэгжүүлсэн түрээсийн орон сууцны хөтөлбөрөөс ямар ялгаатай вэ. Давуу талыг нь дурьдахгүй юу?**

-Түрээсийн орон сууц нь хоёр хэлбэртэй. Тодруулбал, энгийн түрээс болон түрээслээд өмчлөх гэсэн хоёр хэлбэр бий. Сая Төрийн орон сууцны корпорациас иргэдэд сугалаагаар орон сууц түрээслүүлсэн. Манай түрээсийн орон сууц хөтөлбөрийн хамгийн чухал зүйл гэвэл иргэдэд, ялангуяа орон сууцтай болж чадахгүй байгаа зорилтот бүлгийн иргэдэд зориулж түрээслэнгээ өмчлөх боломжийг олгож байгаа юм. Үүгээрээ л онцлогтой. Манай улсад орон сууцанд орох хүсэлтэй боловч санхүүгийн асуудлаас болж орж чадахгүй байгаа залуучууд бий. Тухайлбал, өөрийн гэсэн тодорхой орлоготой хэдий ч ипотекийн зээлд хамрагдаж чаддаггүй. Эсвэл байрны урьдчилгаа мөнгөө төлж чадахгүй байгаа хүн олон байдаг. Тэр хүмүүст илүү сайхан боломж бүрдэж байгаа.

**-Барилгын чанарын хувьд анхаарч байгаа байх. Цаашид өмчлөх хүсэлтэй иргэд бий шүү дээ?**

-Тийм. Түрээсийн орон сууцны барилга 1-2 өрөө бүхий 30-50 мкв байр бий. Барилгын стандарт шаардлагыг хангасан инженерийн шугам сүлжээг бүрэн шийдсэн орон сууц байна.

**-Түрээсийн төлбөр нь хэд вэ?**

-Түрээсийн орон сууцны сарын төлбөр 490-610 мянган төгрөг байна. Харин СӨХ, ашиглалтын зардал нь 80-100 мянган төгрөг. Мөн орон сууц худалдан авах зээлийн урьдчилгаа төлбөр тухайн орон сууцны үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байхаар зохицуулсан.

**-Түрээсийн мөнгөнд урьдчилгаа төлбөрийн хуримтлал орсон уу. Эсвэл тусдаа өгөх ёстой юу?**

-Түрээслээд өмчлөх гэдэг нь хүмүүс урьдчилгаа төлбөрийнхөө 30 хувийг 3-5 жилийн хугацаанд түрээсийн мөнгөнөөсөө бага багаар төлж байгаад тухайн байраа авах боломжтой гэсэн үг. Өөрөөр хэлбэл түрээсийн мөнгөнийх нь 40-50 хувь нь сар бүр урьдчилгаа төлбөр рүү нь орох юм. Харин урьдчилгаа төлбөрөө төлж дуусмагц найман хувийн зээлийн хүү үйлчилнэ.

**-Хэдэн жил түрээслэх боломжтой вэ?**

-Таван жил түрээсэлж болно. Зээлийн үргэлжлэх хугацаа 15-20 жил байна. Урьдчилгаа төлбөрөө төлж дуусвал тухайн орон сууцыг худалдан авах гэрээнд шилжүүлэх боломжтой.

**-Хөтөлбөрийн хүрээнд хэчнээн айлыг орон сууцтай болгох вэ?**

-Энэ жил 1000 айлыг түрээсийн орон сууц хөтөлбөрт хамруулна. Ер нь 2017-2020 он хүртэл жилд 2000 түрээсийн орон сууц барих төлөвлөгөөтэй байгаа. Энэ талаар журамд тусгагдсан.

**-Хөтөлбөрт ямар хүмүүс хамрагдах боломжтой вэ. Тодорхой шаардлага, шалгуур бий юу?**

-Хөтөлбөрт хамрагдах иргэдэд шалгуур үзүүлэлт тавьсан. Тухайлбал, 21-ээс дээш насны нийслэлийн иргэн тогтмол орлоготой байх ёстой. Тухайн иргэний орлого нь түрээсийн төлбөр, урьдчилгаа төлбөрийн хуримтлал, ашиглалтын зардлаа төлөхөд хүрэлцэхүйц байна. Мөн тогтвор, суурьшилтай ажлын байртай, өөрийн эзэмшлийн орон сууцгүй байх гэсэн шалгуурыг тавьж байгаа.

**-Төрийн орон сууцны корпораци иргэдэд сугалаагаар байр түрээслүүлсэн. Танайх яаж олгох вэ?**

-Нийслэлийн орон сууцны корпорацид түрээсийн орон сууцанд хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг оноогоор шалгаруулна. Тодруулбал, гурван төрөлд оноо өгнө. Нэгдүгээрт, гэр хороололд амьдардаг эсвэл өөрийн гэсэн орон байргүй зорилтот бүлгийн иргэнд 20 хүртэлх оноог өгнө. Хоёрдугаарт, Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны стратегийн баримт бичигт тусгагдсан өрхийн орлогын шатлал гэж байдаг. Энэ ангиллыг харгалзаж 50 хүртэлх оноог өгнө. Мөн гуравдугаарт, урьдчилгаа төлбөр бүрдүүлж чадах эсэхийг харгалзаж 30 хүртэлх оноог өгөхөөр болсон.

**-Бүртгэл эхэлсэн үү?**

-Эхэлсэн. Түрээсийн орон сууц хөтөлбөрт хамрагдахыг хүссэн иргэд “Мишээл” дэх төрийн нэгдсэн үйлчилгээний төвд ирж анкет бөглөх ёстой.

**-Анкет бөглөхөд л болно гэсэн үг үү?**

-Тийм.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

### БАГА НАСНЫ ХҮҮХЭД ОСОЛД ӨРТЖЭЭ

Энэ сарын 24-нд бага насны хүүхэд гэмтээсэн хэрэг гарчээ. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн нутаг Зүүн салааны зам, Номин хайрхан хүнсний дэлгүүрийн зүүн замд Н.Accent маркийн авто машины жолооч Н нь явган зорчигч зурган настай эмэгтэй А, дөрвөн настай эрэгтэй Х нарыг мөргөж гэмтээжээ. Иймд Улаанбаатар хотын Замын цагдаагийн газраас бага насны хүүхдээ хараа хяналтгүй орхихгүй байх, замын хөдөлгөөнд гацаарангнь оролцуулахгүй байхыг анхаарууллаа.

### “Херо”-ийн захирал Б.Баатарыг баривчлаагүй гэв

УИХ-ын 2016 оны сонгуульд нэр дэвшигч, “М-Си-Эс” группийн дэд Ерөнхийлөгч Л.Элдэв-Очирын хүсэлтээр “Херо” энтертайнментийн үйл ажиллагааг зогсоож, шалгалт хийж, тус студийн захирал Б.Баатарыг энэ сарын 24-ний шөнө 04:00 цагийн орчим баривчилсан гэх мэдээлэл гарсан. Тэгвэл үүнтэй холбогдуулан Баянгол дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсээс “Херо” энтертайнментийн байранд нэгжлэг хийж, Б.Баатарыг баривчлаагүй талаар өчигдөр мэдээлэл хийлээ. Энэ талаар Баянгол дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн дарга, хурандаа Д.Манлайбаатар “Баянхонгор аймагт МАН-аас УИХ-д нэр дэвшигч Л. Элдэв-Очирын гаргасан гомдлын дагуу “Херо” энтертайнментийн захирал Б.Баатараас тодруулга авах зорилгоор байранд нь очсон хэдий ч найруулагч Б.Баатар “Баянхонгорт ажилтай байна” гэж утсаар ярьсан. Бид гомдлын дагуу студид үзлэг хийх гэсэн боловч тухайн үед н.Лхагвасүрэн хуулийн зөвлөх дуудах хүсэлт өгч, бид хүсэлтийг хүлээн авсан.

Ингээд хуулийн зөвлөхийг нь Гачууртаас иртэл үзлэг хийлгүй хүлээсэн. Гурван цагийн дараа хуулийн зөвлөх Б.Чулуунбат нь студид ирсэн. 20:00 цагийн үед Баянхонгорт ажилтай явж байна гэсэн Б.Баатар 01:00 цагт өөрөө студид хүрээд ирсэн. Тэгээд үзлэг хийлгэхгүй гэж хэлсэн. Бид үзлэгийн өрөөнд албадаж орох үйлдэл хийгээгүй. Бидэнд орох ч боломж олдоогүй. Тэгээд 02:00 цагийн үед явахдаа цагдаагийн хоёр албан хаагчийг урьдчилан сэргийлэх зорилгоор студийн гадна үлдээсэн. Үүний дараа Хошууч н.Солонгийн утас руу яриад, Б.Баатар өмгөөлөгчийн хамт тайлбар өгье гэсэн. Гэтэл одоо болтол тайлбар өгөхөөр ирээгүй байна. Өчигдөр Б.Чулуунбатаас албан тоот ирсэн. Цагдаагийн байгууллага Б.Баатарыг саатуулаагүй, хориогүй, цагдаагүй гэдгээ албан ёсоор мэдэгдэж байна. Б.Баатар захирал руу залгасан ч утас нь ярианд байсан. Бид одоог хүртэл хүлээж байна” гэсэн юм.

### Наймдугаар сард 170 микро автобусыг үйлчилгээнээс хасна гэв

Насжилт нь дууссан өөрөөр хэлбэл 10-20 жил явж буй микро автобуснуудыг өнгөрсөн тавдугаар сард үйлчилгээнээс хасах байсан ч тодорхой шалтгааны улмаас хасагдаагүй билээ. Тодруулбал, хотын ихэнх чиглэлд микро автобус явдаг. Тус автобусаар үйлчлүүлдэг иргэд ч олон бий. Хэрвээ микро автобусыг үйлчилгээнээс хасвал иргэд үйлчлүүлэх унаагүй болох байсан аж. Тэгвэл уг автобусыг орлуулах хэрэгслийг оруулж ирсэн байна. Үүнтэй холбогдуулан насжилт нь дууссан 170 микро автобусыг наймдугаар сараас эхлэн үйлчилгээнээс хасах гэнэ. Сонирхуулахад нийслэлийн хэмжээнд 270 гаруй микро автобус гэрээтэйгээр ажилладаг ажээ.

### Цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалтын нээлт боллоо



“Оюутан цэрэг” хөтөлбөрийн 2016 оны “Цэргийн мэргэжлийн бэлтгэл” шатны сургалтын нээлт БХИС-ийн сургалтын төвд болж, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг болон БХЯ, ЗХЖШ, БХИС-ийн удирдлагууд оролцлоо. “Оюутан цэрэг” хөтөлбөр 2014, 2015 онд амжилттай хэрэгжиж нийт 1500 орчим оюутан тус хөтөлбөрийн сургалтын хөтөлбөрийг бүрэн хангасан бол энэ онд уг хөтөлбөрийн сургалтад 1000 оюутныг хамруулахаар шийдвэрлэжээ. Үүнээс гадна энэ жил зөвхөн нийслэлээс гадна Ховд, Дорнод, Говьсүмбэр зэрэг аймагт хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь хөдөө, орон нутгийн их, дээд сургуулиудын оюутнууд тус хөтөлбөрт хамрагдах өргөн боломжийг олгож байгаагаараа онцлотой гэдгийг нээлтийн үеэр Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хэллээ. “Оюутан цэрэг” хөтөлбөрийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээний хүрээнд шинээр боловсруулсан “Цэргийн албаны тухай” хуулийн төсөлд их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч цэргийн насанд хүрсэн иргэн сайн дурын үндсэн дээр “Оюутан цэрэг” сургалтад хамрагдаж, цэргийн мэргэжил эзэмшин цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэгдэхээр тусгажээ.

PHOTO NEWS

*Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн шинэ барилга ашиглалтад орж, нээлтээ хийлээ. Монгол Улсын Засгийн газраас зориулалтын шинэ барилгыг ашиглалтад оруулах, цус цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах орчин үеийн технологи бүхий цусны албаны техник технологийн иж бүрэн шинэчлэл хийхээр шийдвэрлэсэн. Энэ дагуу Засгийн газрын 2.94 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт болон АХБ-ны 419 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтээр барьжээ.*





*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

### Орон байрны хулгай нэмэгджээ

Орон байр, зуслангийн хулгай их гарч байна, сэрэмжлээрэй, хяналтаа сайжруулаарай хэмээн цагдаагийн байгууллагаас анхааруулсаар байгаа ч энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа аж. Тодруулбал, иргэд зусландаа гарч эхэлсэн энэ үед “Орон байрнаасаа эд зүйлээ алдлаа”, “Зуслангийн байшинд хулгайч оржээ” гэх дуудлага мэдээллүүд цагдаагийн байгууллагад маш ихээр ирж болсон талаар Сүхбаатар дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтсийнхэн ярьж байгаа юм. Хамгийн сүүлд л гэхэд тус дүүргийн цагдаагийн хэлтсийн алба хаагчид бүтэн жил шахам зуслангийн чиглэлд байрлаж, бүлэглэн хулгай хийдэг байсан хоёр этгээдийг илрүүлжээ. Тодруулбал, 2015 оны наймдугаар сараас 2016 оны зургадугаар сарын хооронд Сүхбаатар дүүргийн 19, 20-р хорооны нутаг дэвсгэр буюу зуслангийн чиглэл, Чингэлтэй дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэрт байх иргэдийн зуслангийн байшинд хууль бусаар нэвтэрч, бүлэглэн хулгай хийдэг байсан Э, Г гэгч этгээдүүдийг баривчлан, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн байна.

## Хүчингүйд тооцов

- 9011537149 Улсын бүртгэлийн дугаартай 5953251 регистрийн дугаартай Геоматик инженеринг ХХК-ийн гэрчилгээ,дурэм гээсэн тул
- УБГ00507 дугаартай Эм Эс Ди ХХК-ийн тамга гээгдүүлсэн тул
- “Бүтээлчшинэ сонголт” ХХКомпанийн Нийслэлийн Налайх дүүргийн 6-р хорооны **Шилжрээ гудамжинд байрлалтай**
  1. 000375931 гэрчилгээний дугаартай, Ү-2207004256
  2. 000375930 ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУГААРТАЙ Ү-2207004255
  3. 000375934 ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУГААРТАЙ Ү-2207004259
  4. 000375932 ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУГААРТАЙ Ү-2207004257
  5. 000375933 ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУГААРТАЙ Ү-2207004258

  дугаартай үл хөдлөх, эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ гээгдүүлсэн тул тус тус хүчингүйд тооцов.

# СУРТАЛЧИЛГАА

